



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: (976-51) 26 35 06,

Цахим шуудан: info@mimr.gov.mn,

Цахим хуудас: www.mimr.gov.mn

2025.01.31 № 02/3/6


танай -ны № -т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг биелэлтийн хамт үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНБААТАР



ATA14031 9129294
9024120060

1508 11 0179

d:\ayзбя 2025 Яам а5 docx



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 30

Дугаар 10

Улаанбаатар хот

Тайлан хэлэлцүүлэх тухай

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Удирдлагын зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай тайлангийн танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Өнөмөнх хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох журмаар тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЖАВХЛАНБААТАР

**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ 2020-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2024 оны жилийн эцэс/**

2025 оны 01 дүгээр сарын 31

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын /хуучин нэрээр/ 2021 оны А/71 дугаар тушаалаар баталсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөнд 7 ерөнхий, 22 үндсэн чиг үүргийн 29 зорилт түүнийг хэрэгжүүлэх 99 арга хэмжээ тусгагдсан бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газраас 2024 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Хяналтад авсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий 7, үндсэн 22 чиг үүргийн 29 зорилт 99 арга хэмжээний 2020-2024 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **76.7** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

1. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах – **88.5**
2. Ерөнхий чиг үүргийн нэр: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах – **70**
3. Ерөнхий чиг үүргийн нэр: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах – **70**

4. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах – **41.5**

5. Ерөнхий чиг үүрэг: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх – **100**

6. Ерөнхий чиг үүрэг: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого, чиглэлийг тодорхойлох болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах – **100**

7. Ерөнхий чиг үүргийн нэр: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах – **100**

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2024 оны жилийн эцэс/

Зорилго, зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц /хувиар/							Үнэлгээ /хувиар/
		100	90	70	50	30	0	/-/	
1. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.									
Үндсэн чиг үүрэг-1: Геологийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдлагаар хангах.									
Зорилт-1: Геологийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	4	2	/-/	/-/	2	/-/	/-/	/-/	75
Зорилт-2: Геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн урт хугацааны бодлого, хууль тогтоомжийн төслийн судалгаа хийх, хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах	4	4	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100

ажлыг байгуулах.	зохион								
Үндсэн чиг үүрэг-2: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах.									
Зорилт-3: Бүх төрлийн геологийн судалгааны ажлыг төлөвлөх, төсвийн саналыг боловсруулах, нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг тодорхойлох, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих.	10	9	/-/	/-/	/-/	/-/	1	/-/	90
Үндсэн чиг үүрэг-3: Геологи-хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөх.									
Зорилт-4: Ашигт малтмалын геологи-хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлэх, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	6	5	/-/	/-/	/-/	/-/	1	/-/	83.3
Үндсэн чиг үүрэг-4: Геологи, эрдэс баялгийн үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.									
Зорилт-5:Геологийн салбарын нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих.	2	2	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Дүн	26	22	/-/	/-/	2	/-/	2	/-/	88.5
2. Ерөнхий чиг үүргийн нэр: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бадлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.									
Үндсэн чиг үүрэг-1: Уул уурхайн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.									

Зорилт-1: Уул уурхайн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төсөл, хөтөлбөрийн хувилбар боловсруулах.	4	2	/-/	/-/	2	/-/	/-/	/-/	75
Үндсэн чиг үүрэг-2: Ашигт малтмалын олборлолт, баяжуулалтын хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх									
Зорилт-2: Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах.	23	8	3	3	2	4	3	/-/	65.2
Үндсэн чиг үүрэг-3: Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх.									
Зорилт-4: Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Зорилт-5: Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100

Зорилт-6: Уул уурхайн салбарын судалгаа, шинжилгээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Дүн	30	13	3	3	4	4	3	/-/	70
3. Ерөнхий чиг үүргийн нэр: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.									
Үндсэн чиг үүрэг-1: Газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.									
Зорилт-1: Газрын тосны салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	4	2	/-/	/-/	/-/	2	/-/	/-/	65
Үндсэн чиг үүрэг 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц тогтоох, ашиглалт, олборлолтыг нэмэгдүүлэх.									
Зорилт 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, нөөц тогтоох.	4	3	/-/	1	/-/	/-/	/-/	/-/	92.5
Үндсэн чиг үүрэг: 3: Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах.									
Зорилт 3: Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг дамжуулах хоолойн хамт барьж байгуулах.	2	/-/	/-/	1	/-/	1	/-/	/-/	50
Үндсэн чиг үүрэг: 4: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах.									
Зорилт-4: Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.	3	1	/-/	/-/	1	1	/-/	/-/	60
Дүн	13	6	/-/	2	1	4	/-/	/-/	70

4. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.

Үндсэн чиг үүрэг-1: Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.

Зорилт-1: Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	4	1	/-/	/-/	1	2	/-/	/-/	52.5
---	---	---	-----	-----	---	---	-----	-----	------

Үндсэн чиг үүрэг-2: Тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах замаар хүнд үйлдвэрийг хөгжүүлэх.

Зорилт-2: Хүнд үйлдвэрлэлийг цогцолбороор хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгоно.	9	1	/-/	2	/-/	3	3	/-/	36.7
--	---	---	-----	---	-----	---	---	-----	------

Дүн	13	2	/-/	2	1	5	3	/-/	41.5
------------	-----------	----------	------------	----------	----------	----------	----------	------------	-------------

5. Ерөнхий чиг үүрэг: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх.

Үндсэн чиг үүрэг-1: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

Зорилт-1: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
---	---	---	-----	-----	-----	-----	-----	-----	-----

Үндсэн чиг үүрэг-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах.

Зорилт-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, даван сургах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжилтийг	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
---	---	---	-----	-----	-----	-----	-----	-----	-----

[illegible]

6. Ерөнхий чиг үүрэг: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого, чиглэлийг тодорхойлох болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах.

Үндсэн чиг үүрэг-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ажлыг зохион байгуулах.

Зорилт-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр, зөвлөмжийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх.	2	1	/-/	/-/	/-/	1	/-/	/-/	65
Зорилт-2: Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100

Үндсэн чиг үүрэг-2: Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, судалгаа, мэдээллээр хэрэглэгчийг хангах.

Зорилт-3: Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Зорилт-4: Салбарын хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын талаар судалгаа хийх, статистик мэдээллээр хэрэглэгчийг хангах.	2	2	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Дүн	6	6	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100

7. Ерөнхий чиг үүргийн нэр: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах

Үндсэн чиг үүрэг-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.

Зорилт-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Зорилт-2: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Үндсэн чиг үүрэг-2: АҮЭБЯ, АМГТГ, УГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.									
Зорилт-3: “Эрдэс баялгийн цахим засаглал” хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Зорилт-4: Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээг цахимжуулж, түргэн шуурхай хүргэх.	1	1	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Дүн	4	4	/-/	/-/	/-/	/-/	/-/	/-/	100
Нийт дүн	99	60	3	7	9	13	7	/-/	76.7

Дөрөв. Дүгнэлт.

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл 2024 оны 12 дугаар сарын байдлаар 76.7 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн бөгөөд ерөнхий 7 чиг үүргийн 19 зорилт зорилтод түвшинд хүрч 90-100 хувийн гүйцэтгэлтэй, 3 зорилтын үр дүн тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70-80 хувийн гүйцэтгэлтэй, 7 зорилтын гүйцэтгэл тодорхой хэмжээнд эхэлж боловсруулалтын шатанд буюу 30-60 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн бөгөөд зарим арга хэмжээний биелэлт хангалтгүй буюу үр дүн гараагүй, санхүүжилт тодорхойгүй байгаагаас үнэлэх боломжгүй байна.

Тав. Зөвлөмж.

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний ерөнхий, үндсэн чиг үүрэгт хамаарах зорилтуудын хэрэгжилт удаашралтай байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, цаашид шинээр боловсруулах 2024-2028 оны яамны стратеги төлөвлөгөөнд тусгах зорилт, арга хэмжээг арга хэмжээг хэрэгжихүйц, тодорхой, бодитой боловсруулж тусгах;
2. Стратеги төлөвлөгөөний ерөнхий, үндсэн чиг үүрэгт хамаарах зорилтыг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгойг тухай бүр цуглуулж тайланд хавсаргах /холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр болон албан бичгийн огноо г.м./;
3. Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тайлангийн чанар, утга найруулгыг хянах, тогтсон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх.

Жич: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлтэд 2024 оны жилийн эцсийн байдлаарх үнэлгээг хавсаргав.

ХЯНАСАН:


ХШУДАГ-ЫН ДАРГА



Б.ӨНӨМӨНХ

ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ТАНИЛЦУУЛГА БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ



Ц.ТЭМҮҮЖИН

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2024 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар албан бичгийн Хавсралт 2



СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ
(2020-2024 ОН)

Д/д	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөө (2020-2024)	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн
							2020-2024 он	
1	2	3	4	5	6	7	8	9
1. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.								
Үндсэн чиг үүрэг-1: Геологийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдлагаар хангах.								
1	Зорилт-1: Геологийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	1.1. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/325 дугаар тушаалаар Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулсан. Шинэчлэн боловсруулсан хуулийн үзэл баримтлалын төсөл, үзэл баримтлалын төслийн танилцуулга болон бусад холбогдох материалыг бэлтгэсэн. Хуулийн үзэл баримтлалын төслийг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулах шаардлагатай болсон тул түр хүлээгдэж байна.	50
2		1.2. Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны А/55 болон АҮЭБ-ийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эрдэс баялгийн салбарын ТББ, аж ахуйн нэгж болон бусад холбогдох төлөөллүүдэд танилцуулж, санал авах уулзалт, хэлэлцүүлгийг 2023 онд нийт 9 удаа зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт оролцогчдын саналыг хуулийн төсөлд тусгасан бөгөөд УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.	50
3		1.3. Үндсэн хууль болон бусад хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан	Батлуулсан хуулийн тоо	0	3	Улсын төсөв	Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Газрын хэвлийн тухай хуульд 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр, 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр тус тус нэмэлт, өөрчлөлт орсон. Ашигт	10

		геологийн салбарт мөрдөгдөж байгаа зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулж, батлуулах.					малтмалын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 2024 оны 01 дүгээр сарын 12, 17, 19-ний өдрүүдэд тус тус нэмэлт өөрчлөлт орсон. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2022 оны 12 дугаар сард батлагдаж 2023 оны 06 дугаар сараас эхлэн энэхүү хуулийг дагаж мөрдөж байна. Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сард баталсан ба Цөмийн энергийн тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 20224 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт орсон. Ингэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан УИХ-аас эрдэс баялгийн салбарт шинээр 2 хууль батлагдаж, 3 хуульд 9 удаа нэмэлт өөрчлөлт орсон.	
4		1.4. Геологийн салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, ангилал, норм норматив, аргачилсан зөвлөмж, мэргэжлийн нэр, индексийг боловсруулан батлуулах.	Батлагдсан эрх зүйн актын тоо	8	25	Улсын төсөв	1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн АҮЭБ-ийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 7084 дэх дугаарт бүртгүүлсэн. 2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай журмыг шинэчлэн УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.05.02-ны өдрийн А/87 дүгээр тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5828 дугаарт бүртгүүлсэн. 3. Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг цахиурлаг чулуулаг, барилгын ба өнгөлгөөний чулуу, өнгөт ба эрдэнийн чулуу, гипс ба ангидрит, шавар-шаварлаг чулуулгийн гэсэн 5 төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлуулсан.	101
5	Зорилт-2: Геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн урт хугацааны бодлого, хууль тогтоомжийн төслийн судалгаа хийх, хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах	2.1. Салбарт баримтлах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, цаашид улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулан	Санал боловсруул ах ажлын хувь	0	100	Улсын төсөв	1.Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэх, холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ажлын хэсэг байгуулах тухай ЭЗХ-ийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэгт Бүсчилсэн хөгжлийн хүрээнд геологийн чиглэлээр авах арга хэмжээний саналыг боловсруулан хүргүүлсэн. 2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд геологийн салбарын хэмжээнд авах арга хэмжээний саналыг боловсруулан	100

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

	ажлыг зохион байгуулах.	хэрэгжүүлэх арга хэмжээний санал, салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах					УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/63 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт хүргүүлсэн. 3. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд тусгах Геологийн салбарын хэмжээд авах арга хэмжээний саналыг бэлтгэн АҮЭБ-ийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэгт хүргүүлсэн. 4. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд геологийн салбарын хэмжээнд авах арга хэмжээний саналыг боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн. 5. АҮЭБ-ийн сайдын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл болон 2025 оны төсвийн хязгаарын санал, 2026-2027 оны төсвийн төсөөллийн саналд тусгах геологийн судалгааны ажлын тоо хэмжээ, төсвийн саналыг бэлтгэн СЯ-нд хүргүүлсэн.	
6		2.2. Салбарын хууль, эрх зүйн баримт бичгүүдэд зөрчил, давхардал, хийдэл, эрэлт хэрэгцээ, шаардлагын судалгаа хийх, судалгааны дүгнэлтэд үндэслэн салбарт шаардлагатай хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах.	Санал боловсруулах ажлын хувь	0	100	Улсын төсөв	Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ дэд сайдын 2022.11.02-ны өдрийн 02/2872 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Саналын дагуу Ашигт малтмалын тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон.	100
7		2.3. Салбарын болон холбогдох бусад чиглэлийн бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв	Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд өндөр технологийн түүхий эдийн судалгаа, металл ашигт малтмалын эрлийн ажил хийх чиглэлээр: Стратегийн ашигт малтмал (ГАСАМ) төсөл, өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн “ӨТТЭ-1”, “ӨТТЭ-2” болон Эрэл үнэлгээний 4-н төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
8		2.4. Орон нутгийн удирдлага, иргэдтэй болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, геологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж	Хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт	1.ЭЗХЯ-ны дэргэд байгуулагдсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөл”-ийг боловсруулах Ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр хангах зорилгоор геологи, хайгуулын салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах хэлэлцүүлгийг салбарын эрдэмтэн, судлаачид, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан 2024.01.31-ний өдөр УГА-нд	100

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

		ахуйн нэгж байгууллага, геологичдын дунд чуулга уулзалт зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах.					зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн ЭЗХЯ-нд хүргүүлсэн. 2. "Монголын геологи, хайгуул-2023, 2024" болон "Mining week-2023, 2024" арга хэмжээг зохион байгуулсан. 3. Говь-Алтай аймгийн Баян Уул сумын 2 дугаар багийн иргэдэд Геологийн салбар, геологийн судалгааны ажил, түүний онцлог, хэрэгжилтийг хангах тухай хууль тогтоомж, эрх зүйн акт зэрэг баримт бичиг болон тухайн бүс нутагт гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн тухай уулзалтуудыг зохион байгуулж танилцуулга хийсэн. Уулзалтуудаар сумын иргэдийн асуултад хариулж, геологийн салбарыг сурталчлах ажлыг хийсэн. Мөн сумын Засаг дарга болон сумын захиргааны албан хаагчидтай уулзаж, холбогдох мэдээллээр хангаж ажилласан. 4. Геологийн салбарын ажил мэргэжлийн уралдааныг 2024 онд Орхон аймагт зохион байгуулсан.	
Үндсэн чиг үүрэг-2: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах.								
9	Зорилт-3: Бүх төрлийн геологийн судалгааны ажлыг төлөвлөх, төсвийн саналыг боловсруулах, нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг тодорхойлох, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих.	3.1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	41%	47%	Улсын төсөв	1.Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх геологийн судалгааны 12 ажлын төлөвлөгөө, төсвийг хянаж УУХҮ-ийн /хуучийн нэрээр/ сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар батлуулсан. 2. АҮЭБЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн "Геологийн судалгааны асуудал хэлэлцэх" салбар хуралдаанаар 2024 онд үргэлжлэн хэрэгжих УТХ-өөр хийгдэх 22 төслийн төсөл, төсвийн тодотголыг 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрөөс 06-ны өдрүүдэд хэлэлцэж гаргасан дүгнэлтүүдийг үндэслэн "төсөл, төсвийн тодотголыг батлах тухай" 12 тушаалыг АҮЭБ-ийн сайдаар батлуулсан. 3. ЭБМЗ-ийн "Геологийн судалгааны асуудал хэлэлцэх" салбар зөвлөлийн хуралдаанаар Үнэгт уул-50, Уушгийн улаан-50, Хайрхан овоо-50, Халзан овоо-50, Дөч гол-50, Өндөр ширээт-50, Торлог уул-50, Цэцэрлэг-50, Овоот толгой-50, Алаг баян-50, Оорцог уул-50, Их хараат уул-50 зэрэг төслүүдийн үр дүнгийн тайланг хүлээн авч шийдвэрлэснээр нийт нутаг дэвсгэрийн 47%-ийг энэ төрлийн судалгааны ажилд хамруулсан.	100
10		3.2. 1:25000-ны масштабын геологич орчны судалгааны ажлыг гүйцэтгэх.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	0%	0.15%	Улсын төсөв	Үндэсний геологийн албаны даргын 2024 оны А/27 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд заавар боловсруулахад салбарын бодлого, стратеги төлөвлөгөө, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулах талаар чиглэл өгсөн. Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх геологийн судалгааны	1-

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

							ажлын төлөвлөгөөнд Шинэ Хархорин хотын суурьшлын бүсийн хэмжээнд 1:25 000-ны масштабтай геологийн судалгааг эхлүүлэхээр тусгасан.	
11		3.3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	14%	100%	Улсын төсөв	Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох "УГЗ-200-Д-VII" төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн УТХ-2024-05 дугаар хуралдаанаар хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн. Ингэснээр 2002 оноос хэрэгжүүлж эхэлсэн Улсын геологийн иж бүрдэл зураг зохиох ажил бүрэн хэрэгжсэн.	100
12		3.4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг зохион байгуулах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	63%	70%	Улсын төсөв	Агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай Ховд-2020 төслийн судалгааны үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн УТХ-2024-04 хуралдаанаар хэлэлцэн хүлээн авснаар Монгол орны нутаг дэвсгэрийн 70 %-ийг агаарын геофизикийн судалгаанд хамруулсан. Энэхүү ажлын үр дүнд Монгол Улсын 104,044 км ² нутгийн геологийн тогтцыг зайнаас тандан судалж, соронзон орон, нийлбэр цацраг идэвхжил, газрын калийн агуулга, газрын торийн агуулга, газрын ураны агуулгын зургийг зохиосон байна.	10
13		3.5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг зохион байгуулах.	Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь	65%	100%	Улсын төсөв	Монгол Улс, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км ² талбайд 1:1000000-ны масштабын геохимийн судалгааны ажлыг 2009-2011 онд гүйцэтгэсний үр дүнд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 32.1% хамрагдсан. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 1,062,197.0 км ² буюу үлдсэн 67.9%-д 2019-2022 онд гүйцэтгэсэн 1:1000000-ын масштабтай геохимийн зураглал, дагалдах мэдээллийн сан бүрдүүлэх төслийн ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд Монгол орны нийт нутаг дэвсгэрийг 1:1000000-ын масштабтай геохимийн зураглалд бүрэн хамруулсан.	100
14		3.6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажлыг хийх.	Хэрэгжсэн төслийн тоо	2	7	Улсын төсөв	Эрдэнэт хот, Ховд хот, Дархан хотын суурьшлын бүсийн хэмжээнд гүйцэтгэсэн геоэкологи, гидрогеологийн судалгааны үр дүнгийн тайлан болон Монгол орны төв, хойд бүсийн 602,984.0 км ² талбайн хэмжээнд гүйцэтгэсэн Гүний хагарал төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд 3 хот суурингийн хэмжээнд геоэкологийн өнөөдрийн түвшинг тодорхойлон үнэлгээ өгсөн төдийгүй цаашид экологи-геологийн чиглэлээр авах арга хэмжээний санал бүхий зөвлөмжүүдийг гаргасан. Мөн Монгол орны хойд бүсийн хэмжээнд идэвхтэй гүний хагарлуудыг шинэчлэн тодорхойлж, халуун рашаануудын хэмжээнд геотермийн судалгааг хийж, үнэлсэн.	100

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

15		3.7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажлыг хэрэгжүүлэх.	Хэрэгжсэн төслийн тоо	1	6	Улсын төсөв	1. Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх “Геологийн орчин-2022”, “БМШАМ-2022”, “Ханбогд геохими-2023”, “Ханбогд соронзон-2023” төслүүдийн төсөв, төлөвлөгөөг хянаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. 2. Улсын төсвийн хөрөнгөөр Монгол орны баруун, баруун өмнөд, хангайн бүсийн 557,997.92 км ² талбайн хэмжээнд 2019-2022 онд гүйцэтгэсэн алтны хүдэржилт, хэтийн төлөвийн судалгааны ажил (БӨМ-Алт-2019)-ын тайланг хэлэлцэж хүлээн авсан. ЭБМЗ-ийн хуралдааныг дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2024.04.19-ний өдрийн А/105 дугаар тушаалаар үр дүнг хүлээн авсан.	100
16		3.8. ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх.	Хэрэгжсэн төслийн тоо	1	3	Улсын төсөв	Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан “Хойд, Төв, Зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн 5-р үе шатны “Төв Ази 3D 5-р шат” ажлын 2021-2023 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Үүний үр дүнд Говийн, Алтайн бүс нутгийн хэмжээнд геологийн региональ судалгааны ажлын түвшинг дээшлүүлж, шинжлэх ухааны ач холбогдол бүхий олон тооны баримтуудыг шинээр бүрдүүлсэн.	10
17		3.9. Гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Геологийн албадтай хамтын ажиллагааг сэргээх, харилцан үр ашигтай төсөл хэрэгжүүлэх санал боловсруулах, хэрэгжилтийг хангах	Хэрэгжилтийн хувь	0	100	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	Геологийн салбарт гадаад улс орнуудтай хамтран дараах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: 1.Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын хүрээнд Газрын хэвлийн ашиглалтын хамтарсан Ажлын хэсгийн хуралдааныг 2024 оны 04 сарын 18-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Уулзалтаар хоёр орны геологи, эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр харилцан санал солилцсон. 2.Ховор металл нийлүүлэх сүлжээнд хамтран ажиллах тухай Монгол Улсын УУХҮЯ болон БНСУ-ын ХАҮЭХ-ний яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарны 15-ны өдөр байгуулсан санамж бичгийн хүрээнд “Солонгос-Монголын хамтарсан ховор металлын судалгааны төв байгуулах” төслийн хэлэлцээг Монголын талаас УУХҮЯ /хуучин нэрээр/, СЯ, Солонгосын талаас Солонгосын дэвшилтэт технологийн хүрээлэнтэй 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан. Солонгосын талаас судалгааны төв байгуулах ажлын хүрээнд төвийн барилгын зураг төсөл болон барилгын тендерийг зохион байгуулсан. Мөн КОМИР нь төслийн	100

						монголын инженерүүдийг судалгааны багаж, тоног төхөөрөмж дээр дадлагажуулах сургалтыг БНСУ-д зохион байгуулж, сургалтад 8 инженер хамрагдсан. 3. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын даргын тушаалаар байгуулагдсан Геопаркийн үндэсний хорооны зарим гишүүд 2024 оны 04 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд Геопаркад нэр дэвших боломжтой “Шар цав” үлэг гүрвэлийн мөрт газар ажиллаж, орон нутгийн удирдлагууд, нөлөөллийн бүс дагуух орон нутгийн иргэдтэй уулзаж, үйл ажиллагааны талаарх мэдээллийг өгсөн. “ЮНЕСКО-д бүртгэгдсэн Монголын соёлын болон геологийн өвд түшиглэн тогтвортой аялал жуулчлалыг дэмжих” нь төслийг 2024 оны 6 дугаар сараас эхлүүлсэн. 4. “Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах тухай” Монгол Улс болон Франц Улсын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд ЛиМонголиа төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Төслөөр Чойр-Нялгын депрессийн хэмжээнд хамтарсан судалгааг гүйцэтгэнэ. 5. Монгол Улсын Үндэсний геологийн алба болон БНСУ-ын Гео шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн (КИГАМ)-тэй хамтран Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Хаг нэртэй талбайд судалгааны ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. 6. Монгол Улсын Үндэсний геологийн алба, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Судалгаа, инновацын байгууллагыг төлөөлөх Британийн Геологийн алба хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт талууд гарын үсэг зурсан.		
18		3.10. ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны дүгнэлтэд үндэслэн үр дүнг хүлээн авах	Хүлээн авсан ажлын тоо	5	50	Улсын төсөв	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Улсын төсвийн болон хайгуулын ажлын тайлан, нөөцийн тооцоо хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулсан. Үүнд: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлыг хэлэлцэх хуралдааныг 11 удаа зохион байгуулж, 41 асуудал хэлэлцсэн. Геологийн даалгаврыг бүрэн биелүүлж, холбогдох заавар шаардлагыг хангасан геологийн зураглал, эрэл, сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн 19 тайланг хүлээн авч холбогдох дүгнэлтийг гаргасан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажлыг хэлэлцэх хуралдааныг 17 удаа, өргөтгөсөн хуралдаан 3 удаа тус тус зохион байгуулсан. Хуралдаанаар хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын 104 тайланг хэлэлцэх нөөц баялгийн ангилалын	100

							шаардлага хангасан 89 тайланг хүлээн авч, холбогдох дүгнэлтийг гаргасан байна.	
Үндсэн чиг үүрэг-3: Геологи-хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөх.								
19	Зорилт-4: Ашигт малтмалын геологи-хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлэх, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.	4.1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.	Хэрэгжсэн төслийн тоо	1	3	Улсын төсөв	Чухал ач холбогдолтой ашигт малтмалын судалгааг хийж, хэтийн төлөвийг үнэлэх зорилгоор ӨТТЭ-1-2021 ба ӨТТЭ-2-2022 төслийг хэрэгжүүлсэн. ӨТТЭ-1-2021 төслийг Баруун, Өмнөд болон Төв Монголын хэмжээнд 2021-2023 онд хэрэгжүүлсэн бөгөөд судалгааны ажлын үр дүнгийн тайланг 2024 онд ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн хүлээн авсан. ӨТТЭ-1-2021 төслийн хүрээнд хэтийн төлөвтэй гэж үзсэн Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд, Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт хамаарах 28 талбайг ялган судалгааг хийсэн. Үүний үр дүнд Хангайн гүний хагарлын дагуу Ургамалын металлогений болон Ханхөхийн металлогений бүсийн зааг хэсэгт газрын ховор элементийн Ихэр илрэлийг шинээр илрүүлж, баялгийн үнэлгээ өгсөн. Мөн Баруун Монголд тархсан Годрой бүрдэл ашигт малтмалын шалгуур болох боломжтойг тодорхойлж, үнэт металл, никель-кобалтын хувьд Сулинхээр, Ховдын бүс болон Монгол Улс-ОХУ-ын Тувагийн хилийн бүс хэтийн төлөвтэй тул цаашид нарийвчлан судлахыг зөвлөсөн байна. ӨТТЭ-2-2022 төслийн хүрээнд Монгол орны 104 дүгээр уртрагаас зүүн талын хэсэгт газрын ховор элемент, бал чулуу, никель, кобальт, берилл, литийн чиглэлээр судалгааг үргэлжлүүлэн хийж байна.	10
20		4.2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх.	Хэрэгжсэн төслийн тоо	1	3	Улсын төсөв	1. Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх “Эрэл үнэлгээ-4-2022”, “Мета-алт-500” төслүүдийн төсөв, төлөвлөгөөг хянан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар батлуулсан. 2. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын нутагт 245.01 кв.км талбайд 2020-2022 онд гүйцэтгэсэн “Эрэл-үнэлгээ-1-2020” төслийн үр дүнгийн тайланг УУХҮС-ын 2024 оны А/105 дугаар тушаалаар хүлээн авахаар шийдвэрлэсэн. 3. Өмнөговь аймгийн Цогтцэций, Мандал-овоо, Ханбогд, Манлай, Баян-овоо, Дорноговь аймгийн Мандах сумдын нутагт 4 хэсэг талбайд 2021-2023 онуудад гүйцэтгэсэн “Эрэл-үнэлгээний ажил” /Эрэл-үнэлгээ-2-2021/ болон Өмнөговь аймгийн Цогтцэций, Мандал-овоо, Ханбогд, Манлай, Баян-овоо, Дорноговь аймгийн Мандах сумдын нутагт 4 хэсэг талбайд 2021-2023 онуудад гүйцэтгэсэн “Эрэл-үнэлгээний ажил” /Эрэл-үнэлгээ-2-2021/ төслийн үр дүнгийн тайланг	10

							ЭБМЗ-ийн 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан.	
21		4.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах.	Хил зааг нь батлагдсан ордын тоо	8	16	Улсын төсөв	Стратегийн ач холбогдол бүхий 7 ордын материалыг бүрдүүлж, судалгааг гүйцэтгэж байна. Энэхүү 7 ордын материалд дүн шинжилгээ хийж, талбайн хил зааг тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлохоор ажиллаж байна. Ордуудын талбайн хил заагийг тогтоох саналыг бэлтгэж эхэлсэн. УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 8 ордын талбайн хил заагийг тогтоох бэлтгэл ажлыг гүйцэтгэж, талбайн хил заагийг тогтоон түүний газар зүйн солбицолыг тодорхойлсон хувилбарыг бэлтгэн яамд руу санал авахаар бэлэн болсон боловч Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд "Стратегийн ач холбогдол бүхий орд"-ын тодорхойлолт өөрчлөгдсөнтэй холбогдуулан тухайн асуудлыг Засгийн газарт өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх асуудал тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. УИХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 30 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 88 дугаар тогтоолоор Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарч байгаа хил зааг нь тогтоогдоогүй ордуудын хил заагийг тогтоох саналыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад даалгасан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/77 дугаар тушаалаар дээрх Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан ба тус Ажлын хэсгийн хүрээнд стратегийн ач холбогдол бүхий Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт орших Асгатын мөнгөний орд, Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт орших Төмөртэй-Овоогийн цайрын, Дорнод аймгийн Гурванзагал, Дашбалбар сумдын нутагт орших Дорнодын ураны, Дашбалбар сумын нутагт орших Мардайн ураны, Баяндун сумын нутагт орших Гурванбулагийн ураны ордуудын талбайн хил заагийг тодорхойлж, яамдаас санал авч ЗГХЭГ-т ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Бороогийн алтны үндсэн орд, Төмөртэйн төмрийн хүдрийн орд, Оюутолгойн зэс-алтны бүлэг талбайн хил заагийг тогтоох бэлтгэл ажлыг гүйцэтгэж, талбайн хил заагийг тогтоон түүний газар зүйн солбицолыг	50

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

							тодорхойлсон хувилбарыг бэлтгэн яамдаас санал авахаар хүргүүлсэн.	
22		4.4. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хил, заагийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах.	Хил заагийг батлуулах ажлын хувь	0	100	Улсын төсөв	Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.3, 9.1.11, 17.3-т заасны дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хил заагт нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг бэлтгэн Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн болон 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн. Хуралдаанаас Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолд 2023 оны 268, 447 дугаар тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүний үр дүнд тусгай зөвшөөрөл олгохоор Засгийн газрын 2018 оны тогтоолоор баталсан 8.4 сая гектар талбайд 8.6 сая гектар талбайг нэмж Монгол Улсын хэмжээнд хайгуулын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох боломжтой нийт талбайн хэмжээ 17 сая гектар буюу 10.8% болсон.	100
23		4.5. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх.	Олгосон тусгай зөвшөөрлийн тоо	33	230	Улсын төсөв	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлын хүрээнд 2024 онд 69,412.89 га талбайг хамарсан 71 талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зарлан үнэлгээ хийж, 42 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. Үүний үр дүнд улсын төсөвт 2024 онд 8.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөөнд тусгаснаас 34.8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.	100
24		4.6. Ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлж, геологийн нөөцийг өсгөх.	Улсын нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн ордын тоо	2,250	2,330	Хувийн хөрөнгө оруулалт	Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнд 2024 онд 10 төрлийн ашигт малтмалын нөөц бүртгэгдсэн байна. Үүнээс алт /шороо/ 422.90 кг, төмөр 211.83 мян.тн хүдрээр, хайлуур жонш 1,664.45 мян.тн, нүүрс 7,710.97 сая.тн, шохойн чулуу 27,924.99 мян.тн, дайрга 10.43 сая.м³, өнгөлгөөний чулуу 15,471.79 мян м3, элс 1,129.32 мян.м³, элс-хайрга 1,485.52 мян.м³, базальт 12,251.49 мян.тн-оор Улсын нэгдсэн санд бүртгэн нөөцийг өсгөсөн.	100
Үндсэн чиг үүрэг-4: Геологи, эрдэс баялгийн үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.								
25	Зорилт-5: Геологийн салбарын нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгох	5.1.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг бүх төрлийн геологийн судалгааны ажлын үр дүнгийн мэдээллээр баяжуулах, бүрдүүлэх, мэдээлэл	Хэрэгжсэн төслийн тоо	1	2	Улсын төсөв	Үндэсний Геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд "Геологийн баримт-1-2022" төслийг хэрэгжүүлж байна. Төслийн 2024 оны төсвийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 2024 онд Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн санг Илрэл-3808, Худаг-4575, Цооног-4317, Шлихийн хүрээ-2705, Өрөмдсөн цооног-400, Эрдэсжсэн цэг-155, Давхарга зүйн сан-457,	100

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

	ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих.	түгээх үйлчилгээг хялбаршуулах.					Горизонт-61, Интрузив чулуулгийн сан-1914, Эффузив чулуулгийн сан-360, Палеонтологийн олдворын дэд сан-2171, Үнэмлэхүй насны сан-1119, Нийтлэл-875 буюу нийт 7160 мэдээллээр баяжуулсан.	
26		5.2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах.	Хэрэгжсэн төслийн тоо	0	2	Улсын төсөв	Улсын төсвийн хөрөнгөөр "Цахим архив-1-2022" ба "Чулуун дээжийн сан-1-2022" төслүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2024 оны төсвийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Төслүүдээр 2024 онд Чулуун сангийн агуулахад байгаа ордуудын дээжийг бүртгэх ажлын хүрээнд нийт 165 ордын чулуун дээж- 252, чөмгөн дээж-776, шлиф-621, аншлиф-318, технологийн дээж-6 ширхэг буюу 1973 ширхэг дээж, чулуун дээжийн фото зураг авах ажлын хүрээнд дээжийн-2165, шлифийн-2700, аншлифийн-52 ширхэг фото зургийг авч мэдээллийн бичвэрийг хийсэн байна. Тайлангийн хавсралт материалаас 2736 лабораторийн үр дүнгийн хариуг сканер хийж оруулсан. Цахим архивыг баяжуулах ажлын хүрээнд 839 тайлан, 1261 боть буюу 151, 761 хуудас цахимжуулсан.	100

2. Ерөнхий чиг үүргийн нэр: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага удирдамжаар хангах.

Үндсэн чиг үүрэг-1: Уул уурхайн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

27	Зорилт-1: Уул уурхайн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, төсөл, хөтөлбөрийн хувилбар боловсруулах.	1.1. Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны А/55 болон АҮЭБ-ийн сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: 1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д "хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх аргачлал"-ын дагуу Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан; 2.Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой болон бусад судалгааны тайлан; 3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал; 4.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; 5.Шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсантай холбогдуулан дагалдаж гарах хуулийн төслүүд; 6.Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгасан талаарх харьцуулсан судалгаа; 7.Одоогийн мөрдөж байгаа ашигт малтмалын тухай хуулиас шинэчилсэн найруулгад тусаагүй хасагдсан заалтын харьцуулалт, тайлбар зэрэг болно.	50
----	---	---	------------------------	---	---	-------------	---	----

							Ажлын хэсэг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эрдэс баялгийн салбарын ТББ, аж ахуйн нэгж болон бусад холбогдох төлөөллүүдэд танилцуулж, санал авах уулзалт, хэлэлцүүлгийг нийт 9 удаа зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт оролцогчдын саналыг хуулийн төсөлд тусгасан бөгөөд УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.	
28		1.2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2020.11.02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2020 оны 8 дугаар сард Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалдаа нийцүүлэн боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу яамны цахим хуудас, "Нээлттэй нийгэм форум" болон "Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга" төслийн цахим хуудсанд тус тус байршуулж санал авч, хуулийн төслийн хэлэлцүүлгийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2020.10.06-ны өдөр зохион байгуулж, саналыг тусгасан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хуулийн төсөл, дагалдах хуулийн болон дүрэм, журам боловсруулах үүрэг бүхий олон улсын болон дотоодын зөвлөх 2020 оны 12 дугаар сараас ажиллаж, өмнө боловсруулсан хуулийн төсөлд тулгуурлаж шинэчилсэн хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулсан. Зөвлөхүүдийн ажилласан хуулийн төслийг 2021.04.05-нд Ажлын хэсэгт танилцуулсан. Ажлын хэсгийн гишүүд нь хуулийн төслийн бичвэрийг эцэслэн боловсруулсан. Хуулийн төслийг ХЗДХ-аас хариуцан ахалж ажиллаж байгаа бөгөөд АҮЭБЯ-наас ажлын хэсэгт төлөөлөл оролцон ажиллаж байна.	50
29		1.3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл	100

						баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгааг хийн хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг Эдийн засаг, хөгжлийн сайдад 2022.12.15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох бусад албан бичгүүдийг хүргүүлээд байна. 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсан.	
30	1.4. Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, тандан судалгааны ажлын тайланг хийж гүйцэтгэн, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн 2021.09.27-ны өдөр цахимаар зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д 2022.02.01-ний өдөр өргөн мэдүүлэв. Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу холбогдох Ажлын хэсэг УИХ-ын даргын	100

							захирамжаар байгуулагдаж мөн дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Улсын Их хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт орж дэмжигдсэн бөгөөд 2022.12.14-ний өдрийн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-ын чуулганы эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдэхээр хүргүүлсэн бөгөөд УИХ-ын намрын ээлжит чуулганы 2022.12.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдаад байна.	
Үндсэн чиг үүрэг-2: Ашигт малтмалын олборлолт, баяжуулалтын хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх.								
31	Зорилт-2: Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах.	2.1. Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулах.	Уурхай байгуулах ажлын явц	26 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл	“Оюу толгойн ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол улсын Их хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын 2019 оны 174 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 23 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг ажилласан. (Дээрх ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар, ажлын дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021.02.24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан) Мөн тус яамнаас Ашигт малтмалын тухай хуулийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу “Оюутолгойн далд уурхайн хүдэр тээвэрлэх шугам /үе шат1/-ыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах” тухай техникийн ажлын хэсгийг 2021.02.05-ны өдөр зохион байгуулж, Оюутолгойн далд уурхайг Улсын комисс ашиглалтад бүрэн хүлээж авах хүртэл үйлдвэрлэлийн зориулалтаар түр ашиглах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан. 2021 оны эцсийн байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-89%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-85%, далд уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл-49,943 экв.м, туузан дамжуургын малталт-13,851 экв.м, далд уурхайн бүтээн байгуулалт 78 хувьд хүрсэн байна. Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.09.14-ний өдрийн 01/2234, 2021.10.07-ны өдрийн 01/2423 дугаар албан бичгээр тухай бүрт уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ Сайдын 2021.11.24-ний өдрийн А/284 дүгээр тушаалаар Оюу Толгой төслийн анхдагч мэдээлэл, боловсруулсан өгөгдөлд дүн	100

						шинжилгээ хийж, талуудын мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчдийн хэсэгт техникийн туслацгаа үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан Рио тинто ХХК, Оюутолгой ХХК-ийн төлөөлөлтэй Ажлын хэсгийн гишүүд 2021.11.25-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2022 онд далд уурхайн бүтээн байгуулалтыг 73 хувьд хүргэнэ гэж тусгасан. 2022.12.01-ний байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-90%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-100%, далд уурхайн бүтээн байгуулалт 84%-д хүрсэн. Оюу толгойн уурхайд шаардлагатай бараа материалыг хил гаалиар саадгүй нэвтрүүлэх талаар холбогдох хүсэлтийг Хилийн боомтын зөвлөлд удаа дараа уламжлан ажилласан. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.05.19-ний өдрийн А/113 дугаар тушаалаар “Оюу толгой” ХХК-ийн далд уурхайн бүтээн байгуулалттай газар дээр нь үзэж танилцаж, далд уурхайг ашиглалтад хүлээн авах эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг баталсан. Дээрх тушаалын дагуу УУХҮЯ, ЭХЯ, БОАЖЯ, МХЕГ, АМГТГ, ОБЕГ, Өмнөговь аймгийн засаг даргын тамгийн газар, “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс оюу толгой” ХХК-ийн төлөөлөл оролцсон комисс 2022.05.25-ны өдөр Оюу толгойн далд уурхайд ажиллаж, далд уурхайн бүтээн байгуулалт гүйцэтгэлтэй танилцаж, далд уурхайг хүлээж авах хүртэл, хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгсөн. “Оюу толгой” ХХК-иас Комиссын өгсөн зөвлөмж, даалгаварын хэрэгжилтийн тайланг ирүүлсний дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Оюутолгой” нэртэй зэс, алтны ордыг далд аргаар ашиглах уурхайн 2 дугаар үе шатыг ашиглалтад хүлээн авах тухай шийдвэрийг 2022.08.31-ний өдрийн 22/24 дугаар акт гарсан. 2023 оны 12-р сарын 20-ний байдлаар далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 92.1%, налуу амны туузан дамжуургын угсралтын ажлын гүйцэтгэл 84.3 хувь, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл 33.6 хувь, агааржуулалтын 3-р босоо амны нэвтрэлт 865 метрт, агааржуулалтын 4-р босоо амны нэвтрэлт 959 метрт тус тус хүрээд байна. Далд уурхайгаас хүдэр олборлолтын ажил явагдаж байна.
--	--	--	--	--	--	--

							Цаашид налуу амны дэд бүтцийн угсралтын ажил, агааржуулалтын босоо амнууд болон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулснаар далд уурхайгаас хүдэр гаргах хүчин чадал төслийн хүчин чадалдаа хүрнэ. 2023 оны 11 сарын байдлаар далд уурхайн бүтээн байгуулалтад нийт 5,961 сая ам.долларыг зарцуулсан бөгөөд 2023 онд 497 сая ам.долларыг зарцуулаад байна. 2024 оны байдлаар далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 94.6 хувьд хүрээд байна. Ажлын багцуудаар ангилбал налуу амны туузан дамжуургын угсралтын ажлын гүйцэтгэл 94.3 хувь, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл 50.0 хувь, агааржуулалтын 3-р босоо амны нэвтрэлт 1076 метрт, агааржуулалтын 4-р босоо амны нэвтрэлт 1150 метрт тус тус хүрээд байна. 2024 оны 1-3 дугаар сард Далд уурхайн бүтээн байгуулалтад 151 сая ам.доллар, нийт төслийн хугацаанд 6,216 сая ам.доллар зарцуулсан байна.	
32		2.2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх.	Боловсруулсан хүдрийн хэмжээ	32.0 сая.тн/жил	40 сая.тн/жил	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 13.1 %- ийг, зээлээр 86.9%- ийг (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	ХБНГУ-ын “ЗВ TEC AUFBEREITUNGSSYSTEME” GmbH компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж, метал хийц үйлдвэрлэлийн ажлын явц Бутлуурын байгууламж 100%, Туузан дамжуургын систем 100% дууссан. Нийт металл хийцийн тээвэрлэлтийн ажлын явц 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц Бутлуурын байгууламж 95%, Туузан дамжуургын систем 90%. Овоолгын хэсгийн металл хийц болон механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц 48%-тай байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 24%-ийн гүйцэтгэлтэй байна. Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.11.09-ны өдрийн 01/2725, 2021.12.06-ны өдрийн 03/3022 албан тоотоор тухай бүр уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн. 2022 оны байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 45%-д хүрсэн. Эмulsion тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 70%-тай болж буурсан байна. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д хүрсэн. Засварын	100

						механикийн заводын ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хэлэлцүүлж хүлээн авсан. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 80%-тай байсан. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийн ажилд шаардлагатай бараа материал, үйлдвэрийн тасралтгүй ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын тээвэрлэлтийн ажлыг хил гаалиар саадгүй нэвтрүүлж өгнө үү гэсэн хүсэлтийг Хилийн боомтын зөвлөлд удаа дараа уламжлан ажилласан. Цар тахлын улмаас БНХАУ, ОХУ зэрэг дэлхийн улс орнууд хилээ хаах хүртэл арга хэмжээ авч, онцгой дэглэм тогтоосон, материалын үнийн өсөлт болон тээвэр ложистикийн хүндрэлтэй асуудал үүссэн, Орос-Украины дайны улмаас барууны орнууд ОХУ-ын эсрэг эдийн засгийн хориг тавьж, Европт эрчим хүчний хямрал нүүрлэсэн, инфляцыг дагаад үнийн хөөрөгдөл бий болсон зэрэг давагдашгүй хүчин зүйл, түүний сөрөг үр дагавар нь 2022, 2023 онд ч нөлөөлж буй нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хувьд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн саад, хүндрэл учруулсан байна. 2023 оны байдлаар хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 50%, Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжийн /Өөрөө нунтаглах хэсгийн хүдэр боловсруулах 4-р шинэ шугам, Хам баяжуулалтын 12 сая тн/жил хүчин чадалтай 5-р секцийг шинэчлэх/ төслүүд 100% хийгдэж, одоо Баяжуулах үйлдвэрт 4 төсөл хэрэгжиж байсан.. Засварын механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн төслийн нарийвчилсан ТЭЗҮ болон инженерийн зураг төслийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлж хүлээн авсан. Уг төслийн хүрээнд одоогийн цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл, Механик цехийн өргөтгөл шинэчлэл, шинэ Цутгуурын цех байгуулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж, ажлын гүйцэтгэл 37%-тай байна. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын Ил уурхай, Баяжуулах үйлдвэр, Засвар механикийн заводод өргөтгөл,
--	--	--	--	--	--	--

							шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл дунджаар 84%-тай байна.	
33		2.2.1. Мөчлөгт тээврийн урсгалт технологийг нэвтрүүлэх.	Технологи нэвтрүүлэлт ийн явц	52 хувь	100 хувь.	/Төрийн өмчит компанийн санхүүжилтаар 7.7%-ийг, зээлээр 92.3%-ийг/	Уурхайн тээвэрлэлтийн зай нэмэгдсэнээр олборлолтын зардал ихсэж байгаа тул олборлолтын өөрийн өртгийг бууруулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ хийгдсэн. ТЭЗҮ 100%-ийн гүйцэтгэлтэй. Инженерийн зураг төслийн ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна. 2021 оны байдлаар Конвейерийн системийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 50%. Материал тээвэрлэлт 10%-д хүрсэн. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 35%-д хүрсэн. Метал хийц үйлдвэрлэлийн ажлын явц Бутлуурын байгууламж 100%, Туузан дамжуургын систем 100% дууссан. Нийт метал хийцийн тээвэрлэлтийн ажлын явц 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц Бутлуурын байгууламж 90%, Туузан дамжуургын систем 85% байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 30%-ийн гүйцэтгэлтэй. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлтийн бодит гүйцэтгэл 45%-д хүрсэн гэж бууруулж үнэлсэн байна. Тоног төхөөрөмж үйлдвэрлэх, нийлүүлэх гэрээний хугацаа дууссан. Гэрээг сунгах асуудал төсөвт өртөг нэмэгдсэнтэйгээр хойшлогдоод байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхайн хөрс тээвэрлэлтийн өөрийн өртгийг 10 хүртэл хувиар бууруулах боломж бүрдэнэ. Төслийн ажлыг 2020 оны 05 дугаар сард байгуулсан “түлхүүр гардуулах” нөхцөлтэй гэрээний дагуу ХБНГУ-ын "3BTEC Aufbereitung ssysteme GmbH" ХХК-ийн гүйцэтгэж байна. Гэрээний үнэ 40.7 сая ам.доллар, гэрээний хугацаа 2021 оны 11 дугаар сарын 28-нд дуусахаар гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компанийн зүгээс цар тахал, хил хаагдсан болон тээвэр ложистикийн хүндрэлтэй асуудал зэргээс төслийн ажил графикт хугацаанаасаа ихээхэн хоцорсон тул гэрээний хугацааг сунгах, мөн Орос-Украины дайн, Европ дахь эрчим хүчний хямрал, инфляц зэрэг хүчин зүйлийн улмаас үнэ өссөн гэсэн үндэслэлээр гэрээний үнийг 48 хувиар нэмэгдүүлж, 59.7 сая ам.доллар болгох хүсэлтийг удаа дараа тавьсан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын зүгээс төслийн үнийн дүнг их хэмжээгээр нэмэгдүүлэх гүйцэтгэгчийн санал бодитой эсэхэд	50

						хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлтийг тендерт шалгарсан олон улсын аудитын "Кей Пи Эм Жи Аудит" ХХК-иар гаргуулсан. "Кей Пи Эм Жи Аудит" ХХК-ийн дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэгч компанитай хэлцэл хийж, гэрээний хугацааг сунгаж, гэрээний үнийг 52.67 сая ам.доллороор тохиролцон, 2023 оны 07 дугаар сарын 21-нд гэрээний нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Мөн 2024 оны 07 дугаар сарын 20-ныг хүртэл хийгдэх ажлын календарчилсан төлөвлөгөөг баталсан. Уурхайн мөргөцгийг тулах түшиц ханын угсралтын ажил, суурийн цутгалтын ажил хийгдэж 2,057 м3 М250 маркийн бетон зурмагийн ажил хийгдсэн. 2023 онд 11.97 тэрбум төгрөг, нийт төслийн хугацаанд 832.26 тэрбум төгрөг буюу 55.7%-ийн санхүүжилт хийгдээд байна. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 50%-д хүрсэн.	
34	2.2.2. Эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Шинээр ашиглалтад орсон үйлдвэрийн тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт, Зээл "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК	2021 оны байдлаар Эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100 хувь, бүтээн байгуулалтын ажлын явц 35 хувьтай гүйцэтгэлтэй явж байсан. Ил уурхайн өрөмдлөг, тэсэлгээний хэсэгт эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэр барих ажлыг "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК 2020.05.08-ны өдөр 7/006-20 дугаартай "Ил уурхайн Эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэрийг шинээр барих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ" байгуулж ажил эхэлсэн. Гэрээний үнэ 10.2 тэрбум төгрөг, гэрээний хугацаа 2022 оны 04 дугаар сарын 30-нд байсан. 2021.09.30-ны өдөр гэрээний хугацаа дууссан. 2022.12.31 хүртэл дахин сунгасан. 2023.02.28-нд ашиглалтад оруулахаар дахин төлөвлөсөн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 70%-тай гэж бууруулж үнэлсэн. Цар тахлын халдварын дэгдэлтээс шалтгаалан давагдашгүй хүчин зүйл үүссэн, БНХАУ-ын хил хаагдсан, тээвэрлэлт саатсан, материалын үнэ өссөн зэргээс шалтгаалан хугацаа их алдсан гэх үндэслэлээр гүйцэтгэгч компанийн тавьсан удаа дараагийн хүсэлтийн дагуу төслийн ашиглалтад оруулах хугацааг 2023 оны 06 дугаар сарын 30-н хүртэл сунгасан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ажлын хэсэг уг төслийн ажилд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэж, зохих арга хэмжээ аван ажиллаж байгаа боловч гүйцэтгэгч компаниас шалтгаалан ажил удааширсан. 2023 оны 12 дугаар сарын 20-ний байдлаар барилгын ажил үндсэндээ дууссан гэж гүйцэтгэгч компани мэдэгдсэн.	100

						тул Улсын комисс томилж ажиллуулсан. 2023 онд 1.221 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, нийт төслийн хугацаанд 12.31 тэрбум төгрөг буюу 121% төлбөр хийсэн. (үүнд Нэмэлт ажлын нийт төсөв 1,036 сая төгрөг болсноос 750 сая төгрөг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн. Олон улсын KPMG аудитаар хянагдаж үнийн өсөлтийн зөрүү 471 сая төгрөг шилжүүлсэн.) Эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэрт 2024 оны 03 дугаар сард туршилтын журмаар ажиллуулж нийт 55 тн тэсрэх бодис үйлдвэрлэж туршсан. Агаар сэлгэлтийн системийн угсралтын материалууд 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр төслийн талбайд ирж буусан ба одоогоор хүчит төхөөрөмжүүдийг төслийн талбайд татан авчрах ажил хийгдэж байна. Үүнээс гадна автоматжуулалт, программ хангамжийн ажлууд хийгдэж, сургалт, баталгаажуулалтын ажлуудыг гүйцэтгэсэн байна. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас ажлын хэсэг томилогдон эмulsionийн тэсрэх бодисын үйлдвэрт 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ажиллаж албан даалгавар өгсөн. Улмаар Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын 2025 оны 25Д/01 тоот актаар тус үйлдвэрийн аюулгүйн бүсийг тогтоож, ашиглалтад хүлээн авсан.	
35	2.2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл.	Өргөтгөл, шинэчлэлийн явц	14 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, Зээл	Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.10.04-ний өдрийн 01/2374 тоотой уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн 4-р шугам барьж, байгуулах ажилд БНХАУ-аас нийт 151 инженер, техникийн ажилтан урьж ажиллуулах хүсэлт ирүүлснийг тухай бүр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тодорхойлж өгсөн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өргөтгөл шинэчлэлийн ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, овор ихтэй ачааг хил гаалиар нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор БНХАУ-ын талтай хэлэлцээр хийх асуудлаар ГХЯ, Эрээний гаалиар нэвтрүүлэх ачаа тээвэр, вагоны захиалгыг нэмэгдүүлэх талаар ЗТХЯ-нд албан бичгээр тухай бүр уламжилсан. Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэх байгууламжийг шинээр байгуулах төслийн техник-эдийн засгийн үндэслэлд УУХҮ-ийн /хуучин нэрээр/ Сайдын 2022.02.21-ний өдрийн А/28 дугаар тушаалаар шинжээчдийн багийг томилон, 2022.05.09-ний өдрийн	100

						ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн батлуулсан. 2022.08.26-нд Баяжуулах үйлдвэрийн Өөрөө нунтаглах хэсгийн жилд 6 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай өргөтгөлийн 4-р шугамыг ашиглалтад оруулж, улсын комисс хүлээн авсан. Уг шугамыг нэмж байгуулсанаар баяжмалын гарц 100 мянган тонноор нэмэгдэж, борлуулалтын орлого жилд 200 орчин сая доллараар өснө. Мөн 68 ажлын байр шинээр бий болж байна. Баяжуулах үйлдвэрийн хүдэр боловсруулах хүчин чадлыг шат дараатай нэмэгдүүлэх өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд Өөрөө нунтаглах хэсэгт жилийн 6 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай өргөтгөлийн 4-р шугамыг байгуулах ажил 2019-2022 онд хийгдэж, ашиглалтад ороод байна. Уг шугам нь 2015 онд ашиглалтад орсон 3-р шугамтай тоног төхөөрөмж, технологийн хувьд мөн адил юм. 2022 оны 08 сард эхний 2 төслийн ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулсан. Үлдсэн 3 ажил тендер зарлах түвшинд хэрэгжиж байна. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 100% хүрсэн.	
36	2.2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл.	Өргөтгөл, шинэчлэлийн явц	15 хувь.	100 хувь.	Хувийн хөрөнгө оруулалт, Зээл	Хүйтнээр хатуурах холимгоор хэв бэлтгэх хагас автомат шугамын гүйцэтгэл 100%, засвар, механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон инженерийн зураг төслийг боловсруулах ажил 30 орчим хувьтай, Шинэ Засвар механикийн завод-II төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн техникийн даалгавар боловсруулах ажил хийгдэж байна. Засвар, механикийн заводын Цутгуурын цехийн элчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл шинэчлэлийн ажил 10%. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 20%-д хүрсэн. Засвар, механикийн заводыг хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төслийн ажлыг 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 5/196-21 тоот гэрээний дагуу "Ди Ди Эй Жи" ХХК хийж гүйцэтгэж, 2022 оны 08 дугаар сарын 18-нд АҮЭБЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн дэмжигдэж, тус зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн СТР-2022-02 дугаартай дүгнэлт гарсан. Цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл, шинэчлэлийн барилга байгууламжийг барих ажлын тендерт "Аглут" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгэж байна. 2023 оны 12	50

						дугаар сарын 20-ний өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 51.0 хувьтай байна. Механик цехэд өргөтгөл, шинэчлэл хийж, стандарт бус металл хийцийн болон резин эдлэлийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын зураг төсөл боловсруулах ажлыг 100% хийсэн. Мөн Монгол улсын аж үйлдвэрийг хөгжүүлэх стратегийн хүрээнд машин үйлдвэрлэлийн кластер байгуулах Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах” төсөл буюу Засвар механикийн завод-II төслийн ЗҮТӨҮГ/202101911 тоот нээлттэй тендер шалгаруулалт 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр зарлагдаж, гүйцэтгэгчийг шалгаруулж, 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдөр 6/005-23 дугаартай гэрээ байгуулсан. Төсөл боловсруулах ажил эхэлсэн. Гүйцэтгэгч компани графикт хугацааны дагуу төслийн эхлэлтийн тайланг 2023 оны 11 дугаар сарын 09-ний өдөр хамгаалсан. Төслийн нийт төсөвт өртөг 461.0 тэрбум төгрөг, 2022 оны эцэст гүйцэтгэл 35.5 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 9.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, нийт төслийн гүйцэтгэл 44.7 тэрбум төгрөг байна. Төслийн хүрээнд Цутгуурын цехийн илчин боловсруулалтын тасгийн өргөтгөл, шинэчлэлийн ажлын ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭРТӨҮГ/202201159 тоот нээлттэй тендер 2022 оны 07 сарын 19-нд зарлагдаж "Аглу" ХХК ерөнхий гүйцэтгэгчээр шалгарч, 2022 оны 08-р сарын 18-ны өдөр 7/061/22 ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр ажил эхлүүлсэн. Тус компанийн ажлын нийт гүйцэтгэл 60.6% байна. Суурийн ажил (барилгын аяган суурь, тоног төхөөрөмжийн суурь)-97.5%, газар шорооны ажил-96%, ган бүтээцийн ажил-92%, цэвэр бохир усны шугам угсралтын ажил 35%-тай тус тус үргэлжилж байна. Өнгөрсөн 2022-2023 оны байдлаар Цутгуурын цехийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөлд нийт 11.986 тэрбум төгрөгийн санхүүжилт барилга байгууламж, дэд бүтцийн хүрээнд хийгдсэн байна.	
37	2.3. Цагаансуваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах.	Ашиглалтад орсон ордын тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл	Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус төслийн уулын баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад ашиглагдах тоног төхөөрөмж, материал нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж БНХАУ-ын Эрээн боомтын хил, гаалиар нэвтрэхэд доторхой хүндрэлүүд үүссэн бөгөөд тус яамнаас Хилийн Замын-Үүд боомтын зөвлөлд хандаж бүтээн байгуулалтын	30

							ажилд шаардлагатай бараа материалыг хил, гаалиар саадгүй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2024 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар 2023 онд дараах барилга угсралтын ажлыг гүйцэтгээд байна. Анхан бутлуурын хүчитгэсэн хананы угсралт дууссан, Барилга болон тоног төхөөрөмжийн суурийн цутгалт хийгдсэн. Барилгын металл хийц угсралтыг хийсэн. Мөн туслах тоног төхөөрөмжийн захиалга, үйлдвэрлэл хэвийн үргэлжилж байна. 2023 онд 242.46 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмжийн худалдан авалт, төслийн бүтээн байгуулалтын ажилд зарцуулсан.	
38		2.4. Багануурын уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, өртөг, зардлыг бууруулах.	Олборлосон нүүрсний хэмжээ Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн явц	4.0 сая.тн/жил 51 хувь	5.7 сая.тн/жил 100 хувь	Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж	“Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын тоног төхөөрөмжийг шинэчлэх хүрээнд Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлийг ашиглах дамжуулан зээлдүүлэх гэрээний төслийг батлуулахаар тус яаманд “Эрдэнэс Монгол” ХХК-иас 2021.03.05-ний өдрийн 01/122 дүгээр албан бичгээр ирүүлсэн бөгөөд хариуг 2021.03.15-ны өдрийн 01/593 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Улмаар Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлийг ашиглах дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээг 2021.03.05-ны өдөр байгуулсан байна.	70
39		2.5. Шивээ-Овоогийн нүүрсний өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, өртөг, зардлыг бууруулах.	Олборлосон нүүрсний хэмжээ Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн явц	2.0 сая.тн/жил 36 хувь	2.6 сая.тн/жил 71 хувь	Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж	JBIC-ийн төслийн зээлийн урьдчилгаа төлбөрт 4,468.0 сая төгрөг, зээлийн шимтгэлд 6.85 сая иен тус тус төлсөн. МУ-ын ЗГ-ийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Багануур ХК-ийн парк шинэчлэлт, уурхайн жилийн олборлолтын хүчин чадлыг 5.7 сая тоннд хүргэх санхүүжилтийг ЗГ-ийн мөрийн хөтөлбөрт 2 үе шаттайгаар тусгасан. 2020 онд JBIC-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 29.8 тэрбум төгрөгийн 12 тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн. 2021 онд 2-р шатны техникийн шинэчлэлд шаардлагатай 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэх ёстой боловч өнөөдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй байна. Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%-д хүрсэн. Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%-д хүрсэн. Багануур ХК-ийн парк шинэчлэлт, уурхайн жилийн олборлолтын хүчин чадлыг 5.7 сая тоннд хүргэх санхүүжилтийг ЗГҮАХ-т 2 үе шаттай тусгасан. 2020 онд JBIC-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 29.8 тэрбум төгрөгийн 12 тоног төхөөрөмж шинэчлэлт хийгдсэн.	

						2021 онд 2-р шатны техникийн шинэчлэлд шаардлагатай 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэх ёстой боловч өнөөдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй байна. Шивээ Овоо ХК 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 2 технологийн автомашины урдчилгаа төлбөрийг шийдвэрлэснээр техникийн шинэчлэлийн түвшин 70 хувийн биелэлттэй байна. 2021 онд "Шивээ-Овоо" ХК JBIC төслийн хүрээнд 14.8 тэрбум төгрөгийн зээлийн гэрээгээр Комацу HD465 технологийн автомашин 5, Комацу PC-1250 гидро экскаватор 2 ширхэг нийлүүлэгдэж, эдгээр техникүүдийн төлбөрт 6.6 тэрбум төгрөгийг төлж, одоогийн байдлаар үлдэгдэл төлбөр 8.2 тэрбум төгрөг байна. 2022 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар "Барловорлд Монголиа" ХХК-иас 7.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгийн гэрээтэй нийлүүлсэн CAT777E 2 ширхэг технологийн автомашины төлбөрт 6.8 тэрбум төгрөг төлж, үлдэгдэл төлбөр 1.1 тэрбум төгрөг байна. Дээрх техникүүдийг уулын үйлдвэрлэлд ашиглаж эхэлснээр технологийн автомашины шинэчлэл 30 хувийн биелэлттэй байна.	
40	2.6. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх.	Ашиглалтад орсон ордын тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт	Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2 "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв"-ийн жагсаалтад 500.0 /таван зуун/ сая төгрөгийн төсөвт өртөгийг тусгуулж "Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд ордын штольня-1, штольня-2 болон штольня-5 хэвтээ амнуудаас хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох" нарийвчилсан зураг төслийг хийх ажлын даалгаврыг УУХҮЯ-ны /хуучин нэрээр/ ТНБ даргаар батлуулж, 2021.04.09-ний өдрийн 03/949 дугаар албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. Тус зураг төслийг гүйцэтгэх тендерт шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжээс 2021.09.01-ний өдөр төслийн эхлэлийн тайланг авто замын маршрутын судалгааны хамт ирүүлсэн. 2022 оны байдлаар Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-д хүрсэн. Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэсэн SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15 (Mon)-ны байдлаар гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн.	30

						“Эрдэнэс Монгол” ХХК ТУЗ-ийн 2023.06.20-ны өдрийн №48 тогтоолоор Асгатын мөнгөний ордод ордын геологи, хайгуулын ажлыг гүйцэтгэх, уул техникийн нөхцөл тодорхойлох, уурхайн баримт материалын зураг боловсруулах, нөөцийн тайлан, урьдчилсан ТЭЗҮ боловсруулж, үйлдвэрлэлийн нөөцийг тодорхойлох үүрэг бүхий “Асгат төслийн нэгж”-ийг байгуулсан. Асгат төслийн нэгж 2023.08.01-ний өдрөөс эхлэн ажилласан. Асгатын мөнгөний ордын ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах ажилд “Эрдэнэс Монгол” ХХК 2023 оны төсөвт Асгатын мөнгөний ордыг ашиглах, олборлох боломжийг судлах, олон улсын (JORC) стандартаар хайгуулын ажлыг хийх, бусад холбогдох үйл ажиллагааны санхүүжилтэд нийт 11.1 тэрбум төгрөг тусгасан бөгөөд дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: • Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. • Асгатын ордын уурхайн амнуудыг нээх ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. • Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. • Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /jorc/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан боловсруулж батлуулах ажлын тендер шалгаруулалтыг ТХААГазраас зарлан 2024.02.26-ний өдөр нээлт хийгдсэн. Тухайн тендерт 3-н компани материал ирүүлсэн боловч тендерийн ерөнхий шаардлагыг хангаагүй. Иймд Төрийн худалдан авах ажиллагааны газар дахин нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2024.04.19-ны өдөр нээлт хийсэн. Тухайн тендерт 3-н компани материал ирүүлсэн боловч тендерийн ерөнхий шаардлагыг хангаагүй. Иймд Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 05 дугаар сарын 03-нд дахин тендерийг зарлаад 5 дугаар сарын 29-ны өдрийн үнэлгээний хорооны шийдвэрээр эхний ээлжид ажил гүйцэтгэх компани шалгарсан.
--	--	--	--	--	--	---

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

41	2.6.1. Асгатын мөнгөний ордыг ашиглах туршилт, судалгаа хийх.	Лабораторын туршилт, судалгааны ажлын гүйцэтгэл	50 хувь.	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт 714.5 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/ 2021 он	Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15(Mon)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Орд ашиглах бэлтгэл ажлын хүрээнд далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийх, уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар Монгол 2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. Цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-н чиглэлийн дагуу цуцлагдсан.	/-/
42	2.6.2. Асгатын мөнгөний ордыг ашиглах зөвлөх үйлчилгээ авах.	Зөвлөх үйлчилгээний ажлын явц	55 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт 770.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/	Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг 60%-д хүрсэн. Ордын хэмжээнд 5000 га талбайд М 1:2000 гадаргын бүрэн зураглал хийх, тусгай зөвшөөрлийн хил хязгаар тогтоох шав тэмдэг тавих тендерийн баримт бичиг, техникийн даалгаврыг боловсруулж гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Асгатын нөөцийн тодотголын тайланг хийхээр тендер 2020 онд зарласан. Сонгон шалгаруулалтаар Стийл-Айрон ХХК шалгарсан бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг 2021.06.01-ний өдөр хүртэл сунгасан. Гэрээний хугацааны дагуу боловсруулсан тайланг хүлээж авсан. “Эрдэнэс Монгол” ХХК нь Баян-Өлгий аймгийн Ногооннуур суман дахь өөрийн эзэмшлийн “Асгат”-ын мөнгө, полиметаллын ордын эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай геологи хайгуулын ажил хийх, дэд бүтэц, уулын баяжуулах, боловсруулах, цэвэршүүлэх үйлдвэрийн инженерчлэл, барилгын ажлыг төлөвлөх, ашиглалтад оруулах, бүтээгдэхүүн гаргах, худалдах замаар үр ашигтайгаар ашиглах зорилгоор АНУ-ын “Commonwealth American Partners” хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлтэй “Хамтын ажиллагаа, түншлэлийн санамж бичиг”-ийг 2021.08.30-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан. Компанийн 2020-2023 оны төсөв 150 сая төгрөгийг зөвлөх үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн хэдий ч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас уг тендер зарлагдаагүй.	/-/
43	2.6.3. Асгатын мөнгөний ордод нэмэлт хайгуул хийх.	Нэмэлт хайгуулын ажлын явц	0 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	“Эрдэнэс Монгол” ХХК нь Асгатын мөнгөний ордод олон улсын нөөц баялгийн (JORC) ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт судалгааны ажил	/-/

							хийж, ордын нөөцийг баталгаажуулахаар 2023 оны төсөвт 9.2 тэрбум төгрөг тусгасан. Ордын бэлтгэл ажлын хүрээнд “Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах”, “Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх”, “Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн ажлууд”-ыг ТХААГ-аар зохион байгуулагдаж, тус тендерүүдэд шалгарсан гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-н чиглэлийн дагуу төсвийн санхүүжилт цуцлагдсан.	
44		2.6.4. Асгатын мөнгөний ордын дэд бүтцийн бэлтгэл ажил.	Дэд бүтэц, бэлтгэл ажлын явц	0 хувь	100 хувь	Гадаадын шууд хөрөнгө оруулалт "Эрдэнэс Монгол" ХХК	Өмнөх судалгааны ажлын явцад хийгдсэн Хэвтээ ам-1, Хэвтээ ам-1а, Хэвтээ ам-2, Хэвтээ ам-3, Хэвтээ ам-4, Хэвтээ ам-5-ыг ашиглах боломжийг хангах, нарийвчилсан хайгуулын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дараах тендерүүдийг зарласан: - ЭМГЛ/202306084 дугаартай “Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах” тендерийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. - ЭМГЛ/202306085 дугаартай “Асгатын ордын уурхайн хэвтээ ам нээх” тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулах тухай зөвлөмж ТХААГ-аас 2023.11.29-нд ирсэн бөгөөд ажил гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулсан. - ЭМГЛ/202306088 дугаартай “Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын гурван хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. - ЭМГЛ/202306087 дугаартай “Асгатын мөнгөний ордод гадаргуугийн бүрэн зураглал буюу Топо геодезийн зөвлөх” үйлчилгээний ажилд шалгарсан компанитай гэрээ байгуулсан.	30
45		2.7. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Баяжуулсан нүүрсний хэмжээ	0	10 сая.тн/жил	Хувийн хөрөнгө оруулалт, Зээл /Төрийн өмчит компанийн санхүүжилт ар 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах	УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2020 оны А-292 дугаар тушаалаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод үйл ажиллагаа эрхэлж байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн хэсэг нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд холбогдох дүгнэлтийг 2021.01.22-ны өдөр төсөл боловсруулагчид өгсөн бөгөөд ЭБМЗ-ийн 2021.04.01-ний өдрийн өргөтгөсөн хурлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцэн хүлээн авсан.	90

						гэрээгээр 70%-ийг/	Тавантолгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэх арга хэмжээний тухай тогтооллын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтооллын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 335.6 сая. ам долларын өртөг бүхий жилд 10 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай эхний үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэчийг шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2021.11.15-нд зарласан бөгөөд барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Норинко Интернэшнл Күүперэшн” компани болон “Дади инженеринг девелопмент групп” компаниудын түншлэл шалгаран 2022 оны 4 дүгээр сарын 14-нд гэрээ байгуулсан. Өнөөдрийн байдлаар зураг төслийн гүйцэтгэл 96%, тоног төхөөрөмжийн худалдан авалт 73%, барилгын материалын худалдан авалт 94%, тоног төхөөрөмж, барилгын материалын тээвэр 64%, барилга болон тоног төхөөрөмжийн угсралт 34%-тай тус тус явагдаж байгаа ба төслийн нийт гүйцэтгэл 2023 оны 12 дугаар сарын 26-ний байдлаар 64.41%-тай байна. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэр жилд 10 сая тонн түүхий нүүрс хүлээн авч хоёр төрлийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэрийн барилгын ажил 97.1%-тай, үйлдвэрийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулахаар Орон нутагт хүсэлт хүргүүлсэн.	
46	2.7.1. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийг шинээр нэвтрүүлэх.	Тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт ийн явц	0 хувь.	21 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, Зээл	“Эрдэнэс Тавантолгой” ХК 2021 онд 12ш автосамосвал, 1ш дугуйт ачигч, 1ш бульдозер, 2ш экскаватор шинээр худалдан авсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2021 онд нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 5 хувьд хүргэхээр төлөвлөсөн. 2022 оны байдлаар уурхайд 86 тэрбум төгрөг бүхий 23 ш техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7%-д хүрсэн. 130 тн даацтай автосамосвал 12 ш, 12 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2ш, 7-8 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2 ш, 13.7 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 10 м3 хутганы багтаамжтай дугуйт түрэгч 1ш, 8.5 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 4.3 м3 хутганы урттай автогрейдер 1 ш, тус бүр 20 м3 ёмкостой усны болон түлшний	90	

							автоцистерн зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан байна. 2023 онд Жилд 12 сая.м3 уулын цулын ажил гүйцэтгэх хүчин чадал бүхий 2 ширхэг Liebherr R9200 экскаватор, 2 ширхэг Liebherr R9100 экскаватор, 13 ширхэг 130 тоннын даацтай Belaz 75135 автосамосвалтай хослон ажиллаж байна. Гэрээний дагуу 2023 оны 12 дугаар сард 5ш бульдозер, 9ш автосамосвал, 3ш экскаватор, 2ш автогрейдер хүлээн авсан байна. Төслийн ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн. 2024 оны 1-р улирлын байдлаар 16 сая м3 уулын цулын ажил гүйцэтгэх хүчин чадалтай дараах техникүүдийг хүлээн авсан.Үүнд: Экскаватор: Liebherr 9200/12 м3/- 2 ширхэг экскаватор, Liebherr 9100/7м3/- 2 ширхэг XCMG XDE2000/11 м3/ - 1 ширхэг Liebherr 9400 /угсралтын ажил хийгдэж байна./ Liebherr 9250 /угсралтын ажил хийгдэж байна / Автосамосвал: Белаз 75135 /130 тонн/ - 12 ширхэг XCMG XDE130/120 тонн/ - 9 ширхэг XCMG XDE130- 12 ширхэг /2024 оны 02-р улиралд нэмэгдэнэ./ XCMG XDE240- 44 ширхэг /2024 оны 02-р улиралд нэмэгдэнэ./ Бульдозер: CATD8 – 1 ширхэг Liebherr PR764 - 1 ширхэг Liebherr PR-776 - 5 ширхэг Автогрейдер: CAT14 - 1 ширхэг XCMG GTR3505 - 2 ширхэг Дугуйт түрэгч Белаз 78231 - 1 ширхэг.	
47		2.7.2. Цанхийн баруун уурхайд хөрсний конвейерийн систем нэвтрүүлэх.	Конвейерийн систем нэвтрүүлэлтийн явц	0 хувь	79 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, Зээл "Эрдэнэс-Тавантолгой" ХК	Конвейерийн системийн ТЭЗҮ боловсруулах, зөвлөх үйлчилгээг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн инженерүүд гүйцэтгэж УУХҮ-ий сайдын 2022 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/249 дугаар тушаалаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсгийн шүүмжийг нэгтгэн урьдчилсан байдлаар	30

							2022.10.20-ны өдөр Цахимаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүргүүлсэн. Конвейерийн системийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан 2023.09.12-ны өдөр ЭБМЗ-р хэлэлцүүлж, СТР/23-05-01 дугаар зөвлөмжөөр баталгаажуулсан. Мөн 2023.12.01-ний өдөр "Эрдэнэс Монгол" нэгдлийн техник, технологийн зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-г хэлэлцүүлсэн. Төслийн нүүрс тээврийн конвейерийн системийн ЭТТХК/202310502 дугаар тендерийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зарласан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр тендерийг нээн, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Xinjiang Coal Design and Research Institute" компанитай 04 дүгээр сарын 04-ний өдөр ЭТТ-2024/993 дугаар гэрээг байгуулсан. Төслийн зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлээд байна.	
48	2.7.3. Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 модулийг барьж байгуулах.	Бүтээн байгуулалтын ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, Зээл "Эрдэнэс-Тавантолгой" ХК /Төрийн өмчит компанийн санхүүжилт ар 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/	УУХҮ-ийн сайдын 2020 оны А-292 дугаар тушаалаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод үйл ажиллагаа эрхэлж байгаа "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн баг холбогдох дүгнэлтийг 2021.01.22-ны өдөр төсөл боловсруулагчид өгсөн бөгөөд ЭБМЗ-ийн 2021.04.01-ний өдрийн өргөтгөсөн хурлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцэн хүлээн авсан. Тавантолгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 335.6 сая. ам долларын өртөг бүхий жилд 10 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай эхний үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2021.08.13-ны өдөр зарласан бөгөөд 9 дүгээр сарын 27-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч шалгарсан хуулийн этгээд нь зураг төсөл боловсруулагч Чайна Металлуржикал Инженеринг ХХК-тэй хамаарал бүхий байх тул 2021.11.15-нд тендерийг ахин зарласан байна. Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн барилгын материалын татан авалтыг 2022 оны 10 дугаар сард хийж, суурь судалгааны ажлуудыг бүрэн дуусгасан.	90	

						Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн захиалгыг хийж, үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд анхдагч нүүрс хадгалах агуулахын суурийн цутгалтын ажил явагдаж байна. Нийт ажлын гүйцэтгэл 20%-тай байна. Зураг төслийн гүйцэтгэл 96%, тоног төхөөрөмжийн худалдан авалт 73%, барилгын материалын худалдан авалт 94%, тоног төхөөрөмж, барилгын материалын тээвэр 64%, барилга болон тоног төхөөрөмжийн угсралт 34%-тай тус тус явагдаж байгаа ба төслийн нийт гүйцэтгэл 2023 оны 12 дугаар сарын 26-ний байдлаар 64.41%-тай байна. 2024 оны байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэр жилд 10 сая тонн түүхий нүүрс хүлээн авч хоёр төрлийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэрийн барилгын ажил 97.1%-тай, үйлдвэрийн барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллуулахаар Орон нутагт хүсэлт хүргүүлсэн.	
49	2.7.4. Ачилтын төв нэгдсэн байгуулах.	Бүтээн байгуулалтын ажлын явц	0 хувь	100 хувь	/Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/ "Эрдэнэс-Тавантолгой" ХК	Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төв /салбар төмөр зам, ачих байгууламж/-барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулж, барих тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.07-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлуулсан. Улмаар АҮЭБЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн 2021.11.24-ний өдрийн 16 дугаар хуралдаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлэн хүлээн авсан. Тавантолгойн нүүрсний ордын ачилтын нэгдсэн төв байгуулах ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авсан. Тавантолгойн нүүрсний ордын ачилтын нэгдсэн төвийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтын захиалга хийгдсэн бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажил 2022.04.22-ны өдөр эхэлсэн. Төслийн гүйцэтгэл 44.9%-тай байна. Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн батлагдсан ТЭЗҮ-д 2023 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэгчээс давагдашгүй хүчин зүйл учирсан шалтгаанаар төслийг 2024 оны 1 дүгээр улиралд хэрэгжүүлж дуусгахаар хойшилсон байна. Ачилтын нэгдсэн төв байгуулах төслийн гүйцэтгэл 84.34%-тай байна. Төслийн нийт санхүүжилтэд 254 тэрбум төгрөгийг олгосон байна.	100

							Ачилтын нэгдсэн төвийн барилга байгууламжид 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Улсын комисс ажиллаж, 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн СТР-01 дугаартай актаар байнгын ашиглалтад хүлээж авсан. Тус комиссын бүрэлдэхүүнд Зам, тээврийн яам, Хот байгуулалт, орон сууцжуулалтын яам болон Архивын ерөнхий газрын төлөөлөл оролцсон.		
50		2.7.5 хангамжийн системийг байгуулах.	Усан барьж	Бүтээн байгуулалтын ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт "Эрдэнэс-Тавантолгой" ХК /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/	Тавантолгойн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн бүтээн байгуулалт /нүүрс угаах үйлдвэр, кокс-эрчим хүчний үйлдвэр/-д шаардлагатай 220 л/с усыг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос хангах саналыг Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолын төсөл, танилцуулгад тусган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тавантолгойн нүүрсний ордод түшиглэн байгуулагдах Нүүрс баяжуулах үйлдвэрт шаардлагатай усны хэрэгцээг "Загийн усны хоолой" газрын доорх усны ордоос хангах шугам, хоолой татах барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн 2022 оны төсөвт 72.3 тэрбум төгрөгийг тусгасан. Мөн компанийн зүгээс усны нөөц ашиглахад шаардлагатай дүгнэлт, зөвшөөрлийг БОАЖЯ-ны "Монгол Ус" ТӨҮГ, Галба өөш – Долоодын говийн сав газрын захиргаа зэрэг байгууллагуудаас авсан ба Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос Тавантолгой уурхай хүртэл 70 км шугам хоолой татах трассыг баталгаажуулан захирамж гарган, ус хангамжийн системийг цахилгаанаар хангах техникийн нөхцөлийг ЭХЯ болон Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-аар гаргуулсан. "Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарыг тодорхойлж шийдвэрлүүлэхтэй холбогдуулан Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр болон кокс, эрчим хүчний үйлдвэрт шаардлагатай ус хангамжийг шийдвэрлэх боломжит хувилбарыг боловсруулан ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга (presentation) бэлтгэн 2022.01.26-ны өдрийн засгийн газрын хуралдаанд танилцуулж, ЗГ-ын 2022.01.26-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл гарсан. Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны	70

						хоолой"-н газрын доорх усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг БХБЯ-ны харъяа Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлуулсан. Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "ЧММ" ХХК, "Эс Энд Эй Трейд" ХХК, "Набсан" ХХК-тай гэрээ байгуулсан. 2023.01.06-ны өдрийн байдлаар: Гүний худгийн ажил 77%, Ус цуглуулах шугамын барилга угсралт 48%, Усан сангийн барилга угсралт 81%, Ус дамжуулах гол шугамын барилга угсралт 60%, Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил 81%-тай тус тус гэрээний дагуу гүйцэтгэгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 69.7%-тай байна. "Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах усан хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой" гүний усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг боловсруулж, Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулсан. Загийн усны ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч түншлэлүүдтэй гэрээ байгуулан ажлыг 2022 оны 3 дугаар сараас эхлүүлсэн. Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-тай захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг 2023 08 дугаар сарын 31-ний өдөр байгуулан ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 26-ны байдлаар хийгдсэн ажлыг жагсаавал: Үүнд: -Гүний худгийн өрөмдлөгийн ажил 100%, -Гүний худгийн барилга угсралтын ажил 95%, -4 салбар ус цуглуулах шугамын барилга угсралтын ажил 100%, -2 ш 1500 м3 багтаамжтай усан санг барилга угсралт, доторлох, дулаалах, буцаан булах ажил 100%, -Зөөлөн ширмэн хоолой болон хуванцар хос хоолой угсрах, хийн тест хийх, буцаан булах, Үзлэгийн худгийн хаалт арматур угсрах зэрэг ус дамжуулах гол шугам хоолойн барилга угсралтын ажил 100%, -Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил 93%,
--	--	--	--	--	--	--

						-Өргөлтийн насос станцын барилгын ажил 100% тус тус хийгдсэн. Үргэлжлэн хэрэгжиж байгаа ажил: -2 өргөлтийн насос станцын тоног төхөөрөмж суурилуулах угсрах ажил Цахилгаан дэд станц, хуваарилах байгууламжийн ажил 2 км 35 кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугам ажил Холбоо дохиолол, автоматжуулалтын ажил 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Барилга угсралтын ажил хэвийн явагдаж байгаа бөгөөд нийт төслийн гүйцэтгэл 91.5%-тай байна. 2024 оны байдлаар төслийн гүйцэтгэл: -Загийн усны хоолойн хэсэгт 14 ширхэг гүний худгийн насосыг суурилуулан зураг төслийн дагуу угсарсан. -Барилгын ажил сунгуулах зөвшөөрлийн хүсэлтийг хүргүүлж холбогдох материалуудыг нэмэлтээр бэлдэж хүргүүлсэн. -Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч Барилгын хөгжлийн төвөөс хийгдсэн ажлын тайланг хүлээн авч хянан гэрээнд заагдсан холбогдох санхүүжилтийг өгсөн. - Улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор төслийн талбайд зохиогч, гүйцэтгэгч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч Барилга хөгжлийн төвтэй хамтран 2 удаагийн хяналт хийн, асуудлыг газар дээр шийдэн ажилласан. - Цахилгаан дамжуулах 35-н агаарын шугамын ажлыг бүрэн дуусган зураг төсөл зохиогчоор хянуулан Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гаргасан. Зохиогчийн хяналт хийх гэрээний хугацааг сунган гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан Шилэн кабелийн дотоод хэлхээг бүрэн хийж дуусгасан. Тоолуур, мэдрэгчүүдийг холбогдох хэсэгт угсарсан.	
51	2.8. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах.	Боловсруулсан хүдрийн хэмжээ Төслийн хүчин чадлын ашиглалт	300.0 мян.тн/жил 50 хувь	600.0 мян.тн/жил 100 хувь	“Эрдэнэс алт ресурс” ХХК Хувийн хөрөнгө оруулалт /Төрийн өмчит компанийн санхүүжилтэ эр 100%-ийг/	“Эрдэнэс Монгол” ХХК нь үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-ийн хүрээнд зарцуулалт хийж, арилжааны банкнуудтай гэрээ хийж 228,493.0 иргэн 6 сая төгрөг, түүнээс доош дүнтэй зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөж (үүний 43,892.0 иргэн 1 сая төгрөг хүртэлх зээлтэй), 2021.05.21-ний өдөр 194,807 иргэнд 1 сая төгрөгийн өдөр мөнгөжүүлсэн үнэт цаас эзэмшүүлэх замаар байгалийн баялгийн өгөөжөөс хүртээсэн. (Нийт 423,300 тэтгэвэр авагч иргэн). Жилд 600.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэр-II төслийг хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 90%,	100

						угсралт суурилуулалт 80%, барилгын материалын татан авалт 90%, барилга угсралтын ажил 80%, дэд бүтцийн ажил 80% гүйцэтгэлтэй байна. Ковид цар тахлын нөлөөлөл, хөл хорио, Монгол Улсын хил, гаалийн хориг зэргээс үүдэлтэй шинэ баяжуулах үйлдвэрийн барилгын явц график төлөвлөгөөнөөс хоцорч, үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилгын материалууд 2 сар гаруй хугацаатай Хятад, Монголын хил гааль дээр саатаж байгаа зэрэг нь шинэ үйлдвэрийг төлөвлөгөөт хугацаанаас хоцрогдолтойгоор ашиглалтад оруулах нөхцөл байдал үүссэн. Дээрх хил, гаалийн хоригоос үүдэлтэй хүндрэлийг шийдвэрлэх хүрээнд тус яам нь Хилийн Замын-Үүд боомтын зөвлөлд хандаж бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бараа материалыг хил, гаалиар саадгүй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан. Салхитын мөнгөний ордын нөөцийг нэмэгдүүлж, ордын насжилт өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны хайгуулын ажлын хүрээнд хийгдсэн геологи хайгуулын нарийвчилсан ажлын үр дүнд ордын нөөцийг бодитой ба боломжтой /B+C/ зэрэглэлээр 3,169,815.5 тонн хүдрийн нөөцийг ЭБМЗ-өөр 2021.04.15-ны өдөр хэлэлцүүлж Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн. 2023 оны 03 дугаар улиралд Баяжуулах-2 үйлдвэрийг ашиглалтад оруулсан ба одоогийн байдлаар бүрэн хүчин чадлаар ажиллаж байна. Баяжуулах-2 үйлдвэр ашиглалтад орсноор жилд 600 мян.тн хүдэр боловсруулж, борлуулалтын орлого ойролцоогоор 65%-р өссөн. Түүнчлэн “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023.10.11-ний өдрийн хурлын 03 дугаар, “Эрдэнэс алт ресурс” ХХК хувьцаа эзэмшигчдийн 2023.10.11-ний өдрийн 08 дугаар тогтоолоор “Компани нэгтгэх гэрээ”-ний төслийг баталж, “Эрдэнэс алт ресурс” ХХК, “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн хооронд компани нэгтгэх гэрээг байгуулсан. Гэрээ байгуулснаас хойш “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн тусгай зөвшөөрлүүд, баримт бичиг, эд хөрөнгө болон мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-д шилжүүлсэн. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн эзэмшиж буй Салхитын мөнгө-алтны ордын хүдрийг баяжуулах II дугаар үйлдвэртэй “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах” Улсын
--	--	--	--	--	--	---

						комисс 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр ажилласан бөгөөд байнгын ашиглалтад хүлээж авсан.	
52	2.9. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах.	Ашиглалтад орсон ордын тоо	0	1	"Монголросц ветмет" ТӨҮГ Хувийн хөрөнгө оруулалт, зээл	Зүүн Цагаан Дэлийн орд газрыг далд аргаар ашиглах ТЭЗҮ-ийг (тодотгол) боловсруулж АҮЭБЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн 2021.04.13-ны өдрийн хурлаар шийдвэрлүүлсэн. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ, БОННУ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг батлуулах ажилд дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн төсөл хэрэгжүүлэгч нь цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5км түр агаарын шугамыг барьж, уурхайн налуу ам 80м нэвтэрсэн ба 2021 оны эцэст нэвтрэлтийн хэмжээ 120м-130м-т хүрнэ. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. 2021 оны эцэс, 2022 оны эхээр Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННУ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан байна. Цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан. 2022 оны хагас жилийн байдлаар налуу ам болон бусад малталтуудын хэмжээнд 485 м нэвтэрч 4673 м3 уулын цулын ажил гүйцэтгэсэн байна. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. Зүүн цагаан дэлийн далд уурхайн эхний ээлжийг 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. Зүүн Цагаан дэлийн хайлуур жоншны далд уурхайн 2 налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 1199.5 у.м нэвтэрч, /9894,7 м3 уулын цул нураасан уулын ажил хийж 78.9% гүйцэтгэлтэй байна. Уурхайн доод түвшин 1150 м. Уурхайн дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмпийн барилга байгууламжийн ажил 85% гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 50 хувьд хүрсэн. Уурхайн нэвтрэлтийн ажлын гүйцэтгэл 2021 оноос одоог хүртэл төлөвлөгөөт графикын дагуу 100% гүйцэтгэлтэй байна. Мөн далд уурхайн усыг гадагшлуулах зорилгоор ЦНС-105 маркийн 2 ш насосыг бүрэн суурьлуулж ус соруулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Ингэснээр жоншны хүдэр олборлолтыг 2025 оноос эхлүүлэх ажил төлөвлөгөөт хуваарийн дагуу гүйцэтгэгдэж байна. Бор-Өндөр УБҮ-н тэсэлгээний тусгай зөвшөөрөл сунгах зөвлөлийн хурлаар 2024.01.05-ны өдөр орж 100%-н	100

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

						дэмжлэгтэйгээр 5-н жилээр сунгах дүгнэлт гарсан. Сайдын тушаал 2024.01.26-ны өдөр гарч, 2024 оны хяналтын хуудас 2024.02.08-ны өдөр гарсан. Зүүн цагаан дэлийн үйл ажиллагааг 2024.01.01-ий өдрөөс эхлэн түр зогсоогоод байсан бөгөөд 2024.02.13-ны өдрөөс нэвтрэлтийн ажлыг эхлүүлсэн. 2024 оны 3-р сард 1150 түвшинд 1 болон 7-р хүдрийн биетийг нээх бэлтгэл малталтын ажлыг хийж гүйцэтгэж байна. 5-р сард 76.1у.м/514.3м3 нэвтрэлтийн ажил төлөвлөснөөс 83у.м/594.2м3 хийж гүйцэтгэсэн.	
53	2.10. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж, уурхай, үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Байнгын ашиглалтад хүлээн авсан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн тоо	104	184	Улсын төсөв, Хувийн хөрөнгө оруулалт	“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах түр заавар”-ын төслийг боловсруулж, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ ТНБД-ын 2021.02.08-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулсан. 2021.12.31-ний өдрийн байдлаар нийт 39 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулсан. 2022 онд Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргасан Багануур ХК, Хуучин андууд ХХК, Монгойн гол ХК, Бэрх Уул ХК, Хавчигийн ам ХХК, Цээцээ импекс ХХК, Будар минералс ХХК, Мандах дорнын жонш ХХК, Жамц давс ХХК, Эрдэнэмайнинг үйлс ХХК, Тэвхэн ХХК, Айваору ХХК, Дамбат ХХК, Монгол базальт ХХК, Алтан дун дорнод Монгол ХХК, Уулс заамар ХХК, Монжин далай ХХК, Вестернресурс ХХК, Дэмси трейд ХХК, Алтан гол эксплоерейшн ХХК, Меланж ХХК, Сэлэнгэ минералс ХХК, Хархорум сүлд ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Оюутолгой ХХК, Есөнхаш Эрдэнэ ХХК, Хан-Алтай ресурс ХХК, Монголросцветмет ТӨҮГ, Чамин алт ХХК, Хана интернейшнл ХХК, Идэр макс ХХК, Очир мандал хайрхан ХХК, Түмэн айл инвест ХХК, Стархолдинг ХХК-иудын нийт 34 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай нь газар дээр нь болон цахимаар танилцаж, холбогдох дүгнэлт гаргасан. 2023 онд Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргаж баримт бичгийн бүрдэл хангасан Монрок ХХК, Илт гоулд ХХК, Сүр сүлд ХХК, Мөнх нархан орд ХХК, Ам та тү ХХК, Имперо майнинг ХХК, Галт үнэг ХХК, Скайтимбер ХХК, Болор жонш ХХК, Монфрукт ХХК, Фен шу зун ХХК, Говь ресурс девелопмент ХХК, Түм их эрхэд ХХК, Уулс заамар ХХК, Хан тэнгэрийн дуудлага ХХК, Тахамт ХХК, Эрдэнэс силвер ресурс ХХК, Очир мандал хайрхан ХХК, Адил-Оч ХХК, Хас даваа ХХК, Монголчехметалл ХХК, Говьшоо ХХК-иудын нийт 22 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл	100

							ажиллагаатай нь газар дээр нь болон цахимаар танилцаж, холбогдох дүгнэлт гаргасан. 2024 онд Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргаж баримт бичгийн бүрдэл хангасан Их түмэн хүрд ХХК, Билэгт зурвас ХХК, Мига эрин зуун ХХК, ЭБГ ХХК, Ханшашир ХХК, Баянчулуут газар ХХК, Говь транс ХХК, Мандал ресурс ХХК, Оюут болор эрдэнэс ХХК, Монгол манганейз натурал ресурс ХХК, Монгол экспресс эм эн ХХК, Илч хужирт ХХК, Цагаан элгэн ХХК, Эн юү юү ар эс ХХК, Гантулга трейд ХХК, Хас металл ХХК, Мандах дорнын жонш ХХК, Ууган илч ХХК, Чулуун карьер ХХК, Хөтөл карьер ХХК, Жо-интернэшнл ХХК, Түмэн тал ХХК, Шинэ зуун эхэн ХХК, Хандгайт гол ХХК, Монголиан токен майнинг инвестмент групп ХХК, Мөнгөн нуруу ХХК, Хүннү стийл ХХК, Эвч чулуу ХХК, Си Эм Кей Ай ХХК, Чинг хиеи вей еэ ХХК, Дархан бор хужир ХХК, Эрдэнэс тавантолгой ХК, Таслт дөл ХХК, Шианганюнтун ХХК, Говь-Аргатай девелопмент ХХК, Дуньли ХХК, Флюоритстар ХХК, Шувуун хар уул ХХК, Жэй си си ар ХХК, Майнкрафт консалтинг ХХК, Илчит металл ХХК, Сүх-Индэр ХХК, Сүхжин ХХК, Ресурспартнерс групп ХХК, Чандмань платиниум ХХК, Түмэн тал ХХК, Баянхурай ХХК, Галзоо хан ХХК, Түшиг интернэшнл ХХК, Монфайненс ХХК, Цэн газар ХХК, Би өү эл ди майнинг ХХК, Хаш-Аранга ХХК, Монголросцветмет ТӨҮГ, Доц ХХК, Эн и Си ХХК, Өгөөмөр гавилууд ХХК, Дарханговь ХХК, Цайртминерал ХХК-иудын нийт 60 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай нь газар дээр нь болон цахимаар танилцаж, холбогдох дүгнэлт гаргасан.	
Үндсэн чиг үүрэг-3: Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх.								
54	Зорилт-4: Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг	4.1.Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах.	Боловсруулсан хөтөлбөрийн тоо	0	3	Улсын төсөв	Уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр жил бүр хөтөлбөр/төлөвлөгөө/-ийг батлан хэрэгжүүлж байна. Уг төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээнд санхүүжилт шийдэгдэхгүй байгаагийн улмаас хэрэгжээгүй, хэрэгжсэн арга хэмжээ тус бүрээр тайлан гаргах Салбар хорооны даргад танилцуулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд хүргүүлж байна. Салбар хорооны үйл ажиллагаатай холбоотой дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:	100

удирдлага, зохион байгуулалтаар хангах.							2022 онд: -Жил бүрийн 4 сард “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг Улс орон даяар салбар салбарт зохион байгуулдаг ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт ч мөн ХАБЭА-н сарын аяныг өргөн дэлгэр зохион байгуулдаг. Сарын аяныг салбарын хэмжээнд зохион байгуулах тухай салбар хорооны даргын 2022 оны 4-сард А/24 дугаар тушаал, удирдамжийг батлан аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн. -Сарын аяны хүрээнд 2022.04.14-ний өдөр Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтнуудад “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, шаардлага ISO 45001:2018 стандартын танилцуулах сургалт”-ыг “Монголын алт МАК” ХХК болон Мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо /МОШПА/ ТББ-тай хамтран зохион байгуулсан. -Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Уул уурхайн аврах ангитай хамтран “Уурхай, уулын баяжуулах үйлдвэрүүдийн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах болон салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрхзүйн орчны талаар мэргэшил аргазүйн зөвлөмж өгөх сургалт, зөвлөлдөх уулзалт”-ыг аж ахуйн нэгж, байгууллагуудын ХАБЭА-н ажилтнуудад зохион байгуулсан. -Уул уурхайн салбарын мэдээ, мэдээллийг нийтэлдэг “Эрдэс баялгийн тойм” сонин ХАБЭА-н салбар хорооноос хийж хэрэгжүүлж буй ажил, цаашдын зорилтын талаар цуврал нийтлэл, ярилцлагыг 5, 6 дугаар саруудад нийтэлсэн. -Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг идэвхижүүлэн Салбарын аж ахуйн нэгжүүдийн ХАБЭА-н сайн туршлагын түгээн дэлгэрүүлэх чиглэлд туршлага судлах аялалын уурхайнуудын ХАБЭА-н ажилтнуудын хооронд зохион байгуулж байна. 2022 оны 7 дугаар сард салбар хорооны гишүүд “Монголын алт МАК”-ын хийт бетон болон цонх, хаалганы үйлдвэртэй танилцах, туршлага судлах, хөдөлмөрийн эрүүл мэнд, нөхцөлийн талаар зөвлөгөө өгч ажиллав. -Орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд “Mining week” салбар сурталчлах арга хэмжээний хүрээнд “Нэн түрүүнд ХАБ-2022” Уул уурхайн салбарын салбар хуралдааныг 2022.09.14-ний
---	--	--	--	--	--	--	--

						өдөр Оюутолгой ХК болон МОШПА ТББ-тай хамтран Шангрилла зочид буудлын хурлын бага танхимд зохион байгуулав. Бага хуралд танхимаар 140 гаруй хүн, цахимаар 150 гаруй хүмүүс оролцож, сайн туршлага, уурхайчдын ХАБЭА-н тулгамдсан асуудлаар илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлэв. Уул уурхайн салбарын 100 жилийн хүрээнд “Алтан бамбай-2022” аврах ажиллагааны тэмцээнийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран зохион байгуулж, салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гамшиг, ослоос хамгаалах, аврах, эрэн хайх бэлэн байдлыг хангах, чадварыг эзэмшүүлэх, туршлага солилцох зорилготойгоор 2022.09.29,30-ны өдрүүдэд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын баяжуулах үйлдвэрийн полигон дээр зохион байгууллаа. Тэмцээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 6 баг, Монголын алт МАК ХХК, Бороогоулд ХХК, Баян-Айраг ХХК, Эрдмин ХХК зэрэг багууд урилгаар оролцож, харилцан туршлага судлав. 2023 онд: -ХНХЯ дээр 2023.01.13-ны өдөр зохион байгуулагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны хуралд оролцож, Үндэсний хорооны 2022 үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөөний төсөл, үйлдвэрлэлийн ослын даатгалын сангаас санхүүжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний төсөлд санал өгч оролцсон. -ХНХЯ, ХАБЭА-н Үндэсний хорооноос 2023.05.18-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний чуулганд “Уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн байдал, салбар хорооны үйл ажиллагаа” сэдэвт илтгэл бэлтгэж, танилцуулга хийсэн. -ХНХЯ-наас 2023.05.18-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний чуулган”-д “Уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн байдал, салбар хорооны үйл ажиллагаа” сэдэвт илтгэл танилцуулж оролцсон. -Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хэмжээнд зохион байгуулах тухай ТНБД бөгөөд салбар хорооны даргын 2023 оны А/36
--	--	--	--	--	--	--

						дугаар тушаал, удирдамжийг батлуулан, салбарын нийт аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллахыг АМГТГ-т даалган 2023.04.11-ны өдрийн 03/903 дугаар албан бичгээр хүргүүлсэн. АМГТГ-аас 2023 онд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөгөө ирүүлсэн 459 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тушаал, удирдамжийг хүргүүлэн үүнээс 34 ААН сарын аянд идэвхитэй оролцон, тайлангаа ирүүлсэн, 11 нь үйл ажиллагаа явуулаагүй талаар бичгээр мэдэгдсэн байна. -Улсын Их хурлын Нийгмийн бодлогын Байнгын хороон дээр 2022 онд МУ нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенцийн зүйл заалтууд дотоодын холбогдох хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгааг нягтлах, дүн шинжилгээ хийх ажлын хэсэг байгуулагдсан ба энэ хүрээнд ОУХөдөлмөрийн байгууллагын 176-р конвенцийн хэрэгжилтийн талаар танилцуулгыг боловсруулж, ХНХЯ-нд хүргүүлсэн. 2024 онд. -Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024.01.25-ны өдрийн А/19 дугаар тушаалаар “Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо”-ны бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Салбар хорооны бүрэлдэхүүнд тус яамны ГБГ, ГТБГ, ХҮБГ-аас болон ХНХЯ, АМГТГ, ОБЕГ-ын харъяа Уул уурхайн аврах 09 дүгээр анги зэрэг төрийн байгууллагын төлөөлөл, ажилчдын эрх ашгийг төлөөлөх Монголын Эрчим хүч, Геологи, Уул уурхайн үйлдвэрчний холбооны төлөөлөл, ТББ болон аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогчдын төлөөллийг хамруулан байгуулж, 2024 оны төлөвлөгөөг боловсруулсан, салбар хорооны даргаар батлуулан, гишүүдэд хүргүүлсэн. Доор гол ажлуудыг хийж, хэрэгжүүлсэн. Үүнд: -2024 оны 4 дүгээр сарыг улс орон даяар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сар болгон зарладагтай холбогдуулан “Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ын зохион байгуулах ажлын удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/36 дугаар тушаалаар батлуулан аж ахуй нэгж, байгууллагуудад хүргүүлж ажиллав. - Сарын аяныг дүгнэн тайлан мэдээллийг АМГТГ болон аж ахуй нэгж, байгууллагуудаас авч нэгтгэн ХНХЯ-нд хүргүүлсэн.
--	--	--	--	--	--	---

							-Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын “Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуй”-н тухай 176-р конвенцийн тайлан, 2023 онд ирүүлсэн асуулгын хариуг боловсруулан, салбар хорооны гишүүдээс санал авч, албан бус орчуулгын хамт 2024.08.29-ний өдрийн 03/274 дугаар албан бичгээр ХНХЯ /хуучнаар/ хүргүүлэв. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой ажлаар ажлын байранд дээр танилцах талаар албан хүсэлт ирүүлсний дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны даргаас хорооны даргын өгсөн чиглэлийн дагуу Үндэсний хорооны төлөөлөлд орж 2024.01.11-13-ны өдрүүдэд тус үйлдвэрийн хүнд, хортой нөхцөлтэй зарим ажлын байруудтай танилцан газар нь ажиллаж, санал дүгнэлт өгч ажилласан.	
55	Зорилт-5: Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах.	5.1. Уурхайн нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт, дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах.	Хаалтын менежментийн төлөвлөлтийн тоо	2	6	Улсын төсөв	“Эрдэнэс Силвер Ресурс” ХХК, УУХҮЯ /хуучин нэрээр/ нь Канад улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах” MERIT төсөлтэй хамтран Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө (ХМТ)-г жишиг төсөл болгон боловсруулсан. MERIT төсөл ХМТ боловсруулах ажлыг хэсэгчлэн санхүүжүүлж, жишиг төслийн удирдлага, оролцогч талуудын хамтын ажиллагааг хариуцан ажилласан. Төслийн зүгээс Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулахад тавигдах Монгол улсын холбогдох хууль, эрхзүйн шаардлагуудыг судалж дүн шинжилгээ хийж ажиллаж БОАЖЯ-нд хүргүүлсэн. “Ачит Ихт” ХХК-ын захиалгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших UN-000001 тоот тусгай зөвшөөрөлтэй Катодын зэсийн үйлдвэрийн нуруулдан уусгалт явуулж буй үүсмэл орд буюу II дугаар овоолгын нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны үнэлгээ, нөхөн сэргээлтийн зөвлөх үйлчилгээний “Грийнлэнд Прайндли” ХХК-ийн төслийн багийн инженерүүд боловсруулсан. Дээрх нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/181, А/458 дугаар бүхий хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын	100

							журам"-ын дагуу гүйцэтгэсэн тул Орхон аймгийн аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших UN-000001 тоот тусгай зөвшөөрөлтэй Катодын зэсийн үйлдвэрийн нуруулдан уусгалт явуулж буй үүсмэл орд буюу II дугаар овоолгын нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг хянаж, санал, дүгнэлтийн хамт хүргүүлсэн.	
56	Зорилт-6: Уул уурхайн салбарын судалгаа, шинжилгээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх.	6.1. "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийг байгуулах.	Шинээр байгуулагдсан далд уурхайн музейн тоо	0	1	Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт	- Төсөл, арга хэмжээний сургалт, судалгааны төвийн барилгын засвар өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг "Хөх майдар" ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд гэрээт ажлыг 2021.06.15-ны өдөр хүлээн авахаар ажиллаж байна. - УУХҮЯ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2021.11.29-ний А/287 дугаар тушаалаар "Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв /Хэнтий, Батноров Сум, Бэрх тосгон/" төсөл, арга хэмжээний газрын доор малталт, нэвтрэлтийн ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж, хүлээн авах үүрэг бүхий Комисс байгуулагдаж гэрээт ажлыг дүгнэн акт үйлдэж хүлээн авсан. УУХҮЯ-ны /хуучин нэрээр/ дэргэдэх "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төсөл хэрэгжүүлэх нэгж нь Монгол улсад уул уурхайн хаалтын менежментийн жишиг тогтоох, хаагдсан уурхайг эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчин, оюутан, залуучуудын сургалт судалгааны бааз, аялал жуулчлалын төвийн бүтээн байгуулалтын ажлыг батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу зохион байгуулсан. Өнөөгийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төслийн талбайд гадна шугам сүлжээ, цахилгаан хангамж, өргөх машины барилга угсралт, сургалт судалгааны төвийн барилга засвар, өргөтгөл шинэчлэл, төв вентиляторын барилгын засвар, газрын доорх 810 метрийн урттай сургалтын болон музейн зориулалт бүхий байгууламжуудын малталт нэвтрэлтийн ажлууд, дэд бүтцийн болон инженерийн хангамжийн ажлууд бүрэн хийгдэж, төслийн бүтээн байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний дагуу уурын зуухны барилга, гадна холбоо дохиоллын ажлыг гүйцэтгэж хүлээн авах комиссыг ажиллуулж, мэдээллийн төв болон музейн барилга, гадна тохижилтын ажлын гүйцэтгэгчтэй гэрээг байгуулан гэрээний дагуу ажлыг гүйцэтгэсэн. Төслийн үе шатны ажлын төлөвлөгөөний дагуу "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийн Монголын үйлдвэрлэлийн	100

							түүхэн танхим, Монголын уул уурхайн үүсэл хөгжлийн танхим, эрдсийн музей болон мэдээллийн төвийн интерьер, тохижилт, засварын ажил, түүхийн танхимуудын үзмэр, оюутны дотуур байрны барилгын ажлыг гүйцэтгэн төслийн нээлтийг 2024 оны 08 дугаар сард хийсэн.	
3. Ерөнхий чиг үүргийн нэр: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага удирдамжаар хангах.								
Үндсэн чиг үүрэг-1: Газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.								
57	Зорилт-1: Газрын тосны салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	1.1.Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮС-ын /хуучин нэрээр/ 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс санал авахаар 2021.09.09-ний өдрийн 08/2198 дугаартай албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг судалгааны тайлангуудыг тус тус боловсруулсан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/18 дугаар тушаалаар Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Салбарын холбоодын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус ажлын хэсэг Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2026 оны IV улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	30
58		1.2. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэн 2021.11.17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д яаралтай горимоор өргөн барих тухай 60 дугаар тогтоол баталсан. Үүнтэй холбоотой УИХ-ын хэлэлцүүлэгт орох, ЭЗБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Зөвшөөрлийн тухай хууль 2022.06.17-ны өдөр батлагдсантай холбогдуулан "Газрын тосны	30

							бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж 2023.01.01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлнэ. "Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын 2022.12.09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлагдсан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/18 дугаар тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Салбарын холбоодын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус ажлын хэсэг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны IV улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	
59		1.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан "Зээлийн ерөнхий хэлэлцээр"-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай" хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2021.01.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.	100
60		1.4. Газрын тосны салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, холбогдох бусад журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах.	Боловсруулсан журмын тоо	0	1	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж	"Газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.11.16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6018 дугаарт бүртгүүлсэн.	100
Үндсэн чиг үүрэг 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц тогтоох, ашиглалт, олборлолтыг нэмэгдүүлэх.								
61	Зорилт 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ	2.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлох.	Хөрөнгө оруулалтын хэмжээ	43.9 тэрбум.төг	283.7 тэрбум.төг	Хувийн хөрөнгө оруулалт	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилтын хүрээнд "Петро Матад" ХХК-ийн газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Матад-ХХ талбайн 213.93 км2 газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 265 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн улсын тусгай хэрэгцээний талбайтай давхцал бүхий иргэдийн газрыг	100

байгуулах, тогтоох.	нөөц						чөлөөлөх, газрын нөхөх олговрыг тохиролцох үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж, газар чөлөөлөх гэрээ хийж, нөхөн олговрын хэмжээг тохиролцсон. Түүнчлэн Матад ХХ талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвлөлийн 2020 оны 12-р сарын 25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн УУХҮ-ийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн "Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай" А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг "баталгаат (1Р)" зэрэглэлээр 1151194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137931.0 тонн (1.04 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай (2Р)" зэрэглэлээр 3051724.0 тонн (23.01 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай+боломжтой (3Р)" зэрэглэлээр 5385942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Матад ХХ талбайн газрын тосны нөөцийг бүртгэж авснаар газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болж, баталгаат нөөц 1 сая тоноор нэмэгдсэн. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх хүрээнд 2024 онд газрын тосны хайгуулын 4, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 2, нийт 6 талбайд БХГ байгуулах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2024.10.23-ны өдрийн 135 дугаар тогтоолоор Төв ХХХVI талбай, 136 дугаар тогтоолоор Дарьганга ХХIV талбай, 137 дугаар тогтоолоор Хэрлэн-Тохой ХХVIII талбай, 2024.11.13-ны өдрийн 165 дугаар тогтоолоор Гурванбаян ХХХ талбай, 166 дугаар тогтоолоор Борзон VII талбай, 167 дугаар тогтоолоор Ачит ХХХVII талбайд БХГ байгуулахаар тус тус баталсан. Газрын тосны хайгуулын 4 талбайд 8 жилийн хугацаанд нийт 108.5 сая ам.доллар, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 2 талбайд 10 жилийн хугацаанд нийт 21 сая ам.долларын хөрөнгө оруулалт төлөвлөгдсөн. Ашиглалтыг эрчимжүүлж, нөөцийг өсгөх хүрээнд БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024.01.26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргуулсан. Мөн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын "Галба XI талбайн нөөц бүртгэх тухай" 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар тус
---------------------	------	--	--	--	--	--	---

						талбайн нөөцийг ЭБМЗ-ийн зөвлөмж, дүгнэлтийн дагуу хүлээн авсан. Тус компанийн тооцоолсон ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160,4 мянган тонн газрын тосны нөөцийг шинээр ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Монгол Улсын хэмжээнд хайгуулын ажлын үр дүнгээр 2010, 2012, 2021 онуудад газрын тосны баталгаат нөөцийг 333.79 сая тонн, ашиглалтын баталгаат нөөц 43.40 сая тонноор нөөцийн нэгдсэн санд бүртгэн авсан. Тус ашиглалтын баталгаат нөөцөөс 1996-2023 оны хооронд 11.1 сая тонн газрын тос олборлосон ба үлдэгдэл ашиглалтын баталгаат нөөц 32.0 сая тонн байна.	
62	2.2. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах.	Шинээр байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний тоо	23	32	Хувийн хөрөнгө оруулалт	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/294, 2023 оны А/43, А/198, А/247, А/248, А/249 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн Газрын тосны хайгуулын 15 (5, 5, 2, 1, 1, 1) талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Номгон IX, Дарьганга XXIV, Хэрлэнтохой XXVIII, Борзон-VII талбайнуудад аж ахуй нэгжүүд захиалга ирүүлсэн. Тус 4 талбайд Газрын тосны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу ажлын хэсэг байгуулан ажиллаж ялагчийг тодруулан, Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг Гэрээлэгчтэй хэлэлцэн тохиролцсон. Уламжлалт бус газрын тосны эрлийн ажил гүйцэтгэх гэрээг хангалттай биелүүлсэн гэж дүгнэгдсэн Төв-XXXVI талбайд "Юу Жи Эс" ХХК-тай, Ачит-XXXVII талбайд "Тэмүүжин металс" ХХК-тай тус тус Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаар Гэрээлэгч нартай тохиролцсон. 2017 онд Нээлттэй сонгон шалгаруулалт зарласан Гурванбаян-XXX талбайд ялагчаар шалгарсан "Баянпетролиум" ХХК-ийн шүүхийн маргаан шийдвэрлэгдэж, яамдаас дахин санал авсан. Гурванбаян-XXX, Дарьганга-XXIV, Эрлийн гэрээнээс шилжиж буй "Юу Жи Эс" ХХК-ийн Төв-XXXVI талбайнуудын Бүтээгдэхүүн хуваах гэрээний саналыг яамдаас авч дуусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. 2024 онд газрын тосны хайгуулын 4, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 2, нийт 6 талбайд БХГ байгуулах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2024 оны 135 дугаар тогтоолоор Төв XXXVI талбайд, 136 дугаар тогтоолоор Дарьганга XXIV талбайд, 137 дугаар тогтоолоор Хэрлэн-Тохой XXVIII талбайд, 165 дугаар тогтоолоор Гурванбаян XXX талбайд, 166 дугаар тогтоолоор Борзон VII талбайд, 167 дугаар тогтоолоор Ачит XXXVII талбайд тус тус БХГ байгуулах эрхийг	100

						АМГТГ-т олгох ажлыг зохион байгуулсан. Газрын тосны хайгуулын 4 талбайд 8 жилийн хугацаанд нийт 108.5 сая ам.доллар, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын 2 талбайд 10 жилийн хугацаанд нийт 21 сая ам.долларын хөрөнгө оруулалт төлөвлөгдсөн. 1993 оноос хойш газрын тосны 28, нүүрсний давхаргын метан хийн 7, нийт 35 БХГ байгуулснаас 17 БХГ цуцлагдсан. 2024 оны байдлаар хайгуулын 18 БХГ, ашиглалтын 4, цуцлах 2, БХГ-ний төслийг хэлэлцүүлэх шатанд 1, БХГ байгуулах шатанд 2, газрын тосны хайгуулын нээлттэй 15, нүүрсний давхаргын метан хийн хайгуулын нээлттэй 1 талбай байна.		
63		2.3. Газрын тосны хайгуулын талбайд шинээр орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулах.	Нөөц тогтоосон хайгуулын талбайн тоо	0	1	Хувийн хөрөнгө оруулалт	Газрын тосны Матад ХХ талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвлөлийн 2020 оны 12-р сарын 25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн УУХҮ-ийн сайдын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн "Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай" А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг "баталгаат (1Р)" зэрэглэлээр 1151194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137931.0 тонн (1.04 сая баррель)-оор, "баталгаат+магадлал-тай (2Р)" зэрэглэлээр 3051724.0 тонн (23.01 сая баррель)-оор, "баталгаат+магадлалтай+боломжтой (3Р)" зэрэглэлээр 5385942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. Матад ХХ талбайн газрын тосны нөөцийг бүртгэж авснаар газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болж, баталгаат нөөц 1 сая тоноор нэмэгдсэн. БХГ-т Галба XI талбайн Өлгийн ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Газрын тосны салбар хуралдаанаар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, зохиогчийн хувилбараар нөөцийг хүлээн авах шийдвэр гаргасан. Үүнд Баталгаат зэрэглэл (1Р)-ээр байрандаа анх байгаа газрын тос (ООИР)-ны эзлэхүүн нь 12.5 сая баррель буюу 1.8 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу ашиглалтын баталгаат нөөц нь 1.1 сая баррель буюу 160.4 мянган тонн, магадлалтай зэрэглэл (2Р)-ээр байрандаа анх байгаа газрын тос (ООИР)-ны эзлэхүүн нь 16.5 сая баррель буюу 2.4 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нөөц (Р1+Р2) нь 2.1 сая баррель буюу 295.2 мянган тонн, боломжтой зэрэглэл (3Р)-ээр байрандаа анх байгаа газрын тос (ООИР)-ны эзлэхүүн	100

							нь 21.5 сая баррель буюу 3.1 сая тонн, үүнээс ашиглах хэмжээ буюу баталгаат нэмэх нь магадлалтай нэмэх нь боломжтой нөөц нь (P1+P2+P3) нь 3.4 сая баррель буюу 490.4 мянган тонн байна.	
64		2.4. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Олборлосон тосны хэмжээ	400 мян.тн	900 мян.н	Хувийн хөрөнгө оруулалт	Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК болон Доншен газрын тос Монгол ХХК-ийн татварын маргаантай асуудлаар Засгийн газрын хуралдаанд танилцуулан 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 21 дугаар тэмдэглэл гаргуулсан. Мөн дээрх тэмдэглэлтэй холбогдуулан ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19, Тамсаг-21 болон БХГ-97 талбайн БХГ-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар 2023 оны 05 сарын 29-ний өдрийн 96 дугаар бүхий Ерөнхий сайдын захирамжийг гаргуулан Ажлын хэсгийг МУ-ын сайд ЗГХЭГ-ын даргаар ахлуулаар шийдвэрлэсэн. Уг ажлын хэсэг хуралдаж гишүүдэд хариуцсан асуудлуудаар санал боловсруулж нэгтгэх үүрэг даалгаварыг өгч ажилласан. МУ-ын сайд ЗГХЭГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын Бээжин хотод Хятадын газрын тосны корпорацийн удирдлагуудтай бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаар ажлын уулзалт хийсэн ба Хятадын талаас мөн ажлын хэсэг гаргаж хамтран ажиллах талаар санал солилцсон. Монгол Улсын хэмжээнд 2023 онд 6.5 сая баррель буюу 883.7 мян.тн газрын тос олборлож экспортлохоос 2023 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар нийт 4.8 сая баррель буюу 657.1 мян.тн газрын тос олборлож, 4.7 сая баррель буюу 633.9 мян.тн газрын тосыг БНХАУ-д экспортлосон. “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх Монголын талын Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар албажуулсан. “Петрочайна дачин тамсаг” ХХК болон “Доншен газрын тос (Монгол)” ХХК-тай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх Монголын талын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Татварын ерөнхий газрын дарга нарыг оролцуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар захирамжаар дахин шинэчлэн байгуулсан. Тус	70

							ажлын хэсгийн удирдамжаар дээр дурьдагдсан татвар, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг асуудлыг шийдвэрлэхээс гадна цаашид "Петрочайна дачин тамсаг" ХХК болон "Доншен газрын тос (Монгол)" ХХК-иудтай байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх талаар санал, дүгнэлт гаргах талаар чиглэл өгч баталсан. "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн дансыг царцаасан асуудлыг 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулсан бөгөөд танилцуулгатай холбоотой тэмдэглэлийг гаргуулсан. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан болон албаны бусад хүмүүс 2024 оны 10 дугаар сард "Хятадын газрын тос, байгалийн хийн корпораци"-ийн ТУЗ-ын дарга Дай Хоулян болон тус компанийн удирдлагуудтай БНХАУ-ын Бээжин хотноо уулзсан бөгөөд тус уулзалтын үеэр "Петрочайна дачин тамсаг" ХХК-д үүссэн нөхцөл байдлыг судалж нэгдсэн ойлголтод хүрэх талаар харилцан тохиролцсон. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар "Дорнод аймагт газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа "Петрочайна Дачин тамсаг" ХХК-тай холбогдох татварын актын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулсан. Үүнтэй холбогдуулан Петрочайна Дачин тамсаг" ХХК-д ногдуулсан татварын акттай холбогдуулан үүссэн маргааныг шийдвэрлэх асуудлыг нарийвчлан судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан нарт даалгаад байна. 2024 онд 4.8 сая баррель буюу 659.2 мян.тн газрын тос олборлож экспортлохоос 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 4.22 сая баррель буюу 562.6 мян.тн газрын тос олборлож, 4.1 сая баррель буюу 555.6 мян.тн газрын тосыг БНХАУ-д экспортлосон. Газрын тосны ашиглалтын Матад ХХ талбайн Цэн тогоруу ордын газрын тосны олборлолтын ажлыг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр эхлүүлсэн.	
Үндсэн чиг үүрэг: 3: Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах.								
65	Зорилт 3: Дотоодын түүхий эдэд тулгуурласан	3.1.Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий	Шинээр баригдсан	0	1	Засгийн газрын баталгаатай	Түүхий тос дамжуулах хоолойн зураг төсөлд магадлал хийх экспертийн баг БХБЯ-ны харъяа БХТ дээр томилогдон ажиллаж байна. Трассын дагуух газрыг	70

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

	газрын тос боловсруулах үйлдвэрийг дамжуулах хамт барьж байгуулах.	эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх.	дамжуулах хоолой			зээл, хувийн хөрөнгө оруулалт 176,700.0 Хувийн хэвшил 2021 он	улсын тусгай хэрэгцээнд авахуулахтай холбоотойгоор трассын дагуу хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцсан асуудлыг АМГТГ-т хандаж шийдвэрлүүлсэн бөгөөд газрыг тусгай хэрэгцээнд авахуулах хүсэлтийг 2023.06.27-ны өдөр албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. 2023.11.01-ний байдлаар байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн ажил - 90%, Худалдан авалт-6.08% явагдаж байна. БОННУ хийх ажил-100%, Түр кемпүүдийн барилга угсралтын ажил -48%, түр замын ажил -28%, Төслийн ерөнхий гүйцэтгэл Инженерчлэл-70,0%, Барилга угсралт-38,6%-ийн гүйцэтгэлтэй байна. Тос дамжуулах хоолойн трассын дагуу байр зүйн зураглал, инженер геодези, хээрийн судалгааны ажлыг эхлүүлж нарийвчилсан солбицлын цэгүүдийг тодорхойлон хоолойн трассын тэнхлэгээс 2 тал руу тус бүр 100 метр (нийт 200 м) зурвас газарт аливаа газрын давхцыг арилгасан. Хоолой дайран гарах Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймагт дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан улсын тусгай хэрэгцээнд авахыг эдгээр аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр тус тус гарсан. Хоолойн трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай БХБЯ /хуучнаар/-аас ирүүлсэн 3Г-ын "Нууц" тогтоолын төсөлд 2024.03.20-гы өдрийн 01/.... дугаартай албан бичгээр хариуг хүргүүлсэн. Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудал 3Г-ын 2024.05.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэж шийдвэрлэгдсэн. Бүтээн байгуулалтын ажилд тулгамдаад байсан асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 3Г-ын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч Норинко компанид барилгын ажмл эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулсан. Төслийн гүйцэтгэл 2024.12.01-ний өдрийн байдлаар нийт 520,2км шугам хоолойг цувьж байрлуулан, 515,4км шугам хоолойг гагнаж 350,7км шугам хоолойг булж далдлах ажил хийгдсэн, гүйцэтгэл 2024.5.01-ний байдлаар 80,8%-тай.	
66		3.2.Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах.	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо	0	1	Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж /БНЭУ-ын 3Г-ын хөнгөлөлттэй зээл/	Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн бүс барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2023.10.30-ны өдрийн байдлаар 98.6%-тай байна. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /ЕРС-2/ нийт 42 байгууламж барихаас 13 байгууламжийн суурийн ажил 70%, 8 байгууламжийн ул бетон цутгалт 60%, 5 байгууламжийн арматурчлалын ажил 70%-ийн тус тус гүйцэтгэлтэй	30

							байна. Багц ажлын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0,79%-тай байна. Үйлдвэрийн цахилгаан станц /EPC-3/-ын суурийн ажил 100%, бетон цутгалтын ажил үргэлжлэн хийгдэж байна. Багц ажлын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1,32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /EPC-4/-ийн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг байгуулсан. Багц ажлын санхүүжилтийн талаар авах арга хэмжээний тухай ЗГ-ын 2023.9.13-ны өдрийн 336-р тогтоолоор зарим байгууламжийг барих гэрээг байгуулахаар шийдвэрлэсний дагуу төсөл хэрэгжүүлэгч МГТБҮ ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компанитай гэрээг байгуулаад байна. Засгийн газрын 2024.04.24-ний өдрийн 170 дугаар тогтоолоор төслийн ерөнхий гүйцэтгэгч “Мега Инженеринг” компанид барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгуулах ажлыг зохион байгуулсан. Мөн өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр ААНОАТТХуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн ба хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2024.05.31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Төслийн гүйцэтгэл тайлант хугацаанд EPC-01 багц 100 хувь дууссан бол EPC-02 багц 23.8 хувь, EPC-03 багц 17.0 хувь, EPC-04 багц 8.0 хувь, ерөнхий дүнгээр 21.2 хувийн гүйцэтгэлтэй байна.	
Үндсэн чиг үүрэг: 4: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах.								
67	Зорилт-4: Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах.	4.1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой нэмэгдүүлэх.	Бүтээгдэхүүн ний хэмжээ	2.0 сая тонн	2.4 сая тонн	Хувийн хөрөнгө оруулалт 2,834,500.0 2022 он	Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах, чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг жил бүр зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар нийт 2.7 сая тн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон. Үүнд: 90-ээс доош октантай автобензин 5,630 тн, 90-ээс дээш октантай автобензин 845,880 тн, дизель түлш 1,559,497 тн, шатдаг хий 43,438 тн, ТС-1 агаарын хөлгийн түлш 77,465 тн, бусад газрын тосны бүтээгдэхүүн 171,848 тн байна. Шатахууны хангажийг тогтвортой ханган ажиллаж байна.	100
68		4.2.“Евро-5” стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Евро-5 стандартын шатахууны эзлэх хувь	13 хувь	50 хувь	Хувийн хөрөнгө оруулалт	Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100% импортоор хангаж байгаа бөгөөд 2023.12.31-ний өдрийн байдлаар нийт 2,4 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн, үүнээс 2,1 сая.тонн шатахуун импортолсон байна. Үүнд: дизелийн түлш 1.3 сая.тонн,	30

							автобензин 728,9 мян.тонн байгаагаас K5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин 103,256 тонн, дизелийн түлш 128,986 тонн, нийт 232,242 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 11 хувийг эзэлж байна. ОХУ-ын Роснефть компаниас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ литр тутамдаа 200-250 төгрөгөөр өндөр байна. Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2024 онд нийт 2.8 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэнээс, 2.6 сая тонн шатахуун байна. Үүнээс Евро-5 /K5/ стандартын шаардлагад нийцсэн 362 мян.тонн шатахуун байгаа нь нийт импортолсон шатахууны 14.5 хувийг эзэлж байна. Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар мөн Эрдэнэс Монгол ХХК-д тус тус өөрийн харьяа байгууллагууд болон бусад хамтран ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийн хэмжээнд түлш, шатахууны худалдан авалтын сонгон шалгаруулалтыг зарлахдаа зөвхөн экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартад нийцсэн автобензин, дизель түлш сонгох шаардлага тавьж, гэрээ байгуулах, хэрэглээ, худалдан авалтыг тогтмол нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, бидний ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах талаар санал хүргүүлсэн.	
69	4.3."Шатдаг хийн хадгалалт, түгээлтийн үеийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбогдсон стандарт, дүрмийг боловсронгуй болгох.	Баримт бичиг боловсруулалтын хувь	0 хувь	100 хувь	Улсын төсөв	Шингэрүүлсэн байгалийн хийн бага хүчин чадлын үйлдвэрлэл болон хийн ашиглалт. Галын аюулгүй байдлын шаардлага /БНД/, Шингэрүүлсэн байгалийн хийн агуулах. Галын аюулгүй байдлын шаардлага /БНД/ нормын төсөлд санал боловсруулан Барилгын хөгжлийн төвд 2021.03.22-ны өдрийн 1/1188 дугаар албан бичиг хүргүүлэв. Ашигт малтмал, газрын даргын 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/109 тоот тушаалаар "Шингэрүүлсэн нүүрс-устөрөгчийн хий-Автотээврийн түлшний стандарт"-ыг шинэчлэн боловсруулж төслийг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/5186 тоот албан бичгээр Стандарт, хэмжилзүйн газарт хүргүүлсэн. АМГТГ-ын Даргын 2022.03.31-ний өдрийн А45 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж "Хийн хангамж" БНБД /42-01-21/-ийн төсөлд холбогдох дүгнэлт, шүүмжийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-т 2022.05.23-ны өдрийн 22/19 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	50	

							АМГТГ-ын Даргын 2022.08.19-ний өдрийн А/92, 2023.01.09-ний өдрийн А/.. дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж шингэрүүлсэн шатдаг хийн “Зөөврийн бутан хий хадгалах зориулалттай сав үйлдвэрлэх байгууламж, үзлэг, туршилт”, “Дотоод эзлэхүүн 1 литрээс бага багтаамжтай даралтат саванд бутан хий цэнэглэх тоног төхөөрөмжид тавигдах шаардлага болон аюулгүй ажиллагаа”-ны стандартын төсөл шинээр боловсруулав.	
4. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.								
Үндсэн чиг үүрэг-1: Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.								
70	Зорилт-1: Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах.	1.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	УУХҮ-ийн /хуучин нэрээр/ яамнаас боловсруулан 2019.03.20-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Бямбацогтын санаачилсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нэгтгэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд УУХҮЯ-ны /хуучин нэрээр/ төлөөлөл ажилласан бөгөөд Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ болон Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын 2022.07.05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталж, 2022.08.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.	100
71		1.2. Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах.	Батлуулсан хуулийн тоо	0	1	Улсын төсөв	Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдөр баталсан. Хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлэн дэмжигдэж 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-ын даргын 2022.03.30-ны өдрийн 46 дугаар захирамжаар УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалалд оруулсан.	30

						УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдаас Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцэж баталсны дараа УИХ-аар хэлэлцүүлэх чиглэл өгч, УИХ-д өргөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хамт эргүүлэн татах хүсэлтийг УУХҮ-ийн сайдын 2022.12.16-ны өдрийн 01/3323 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023.01.11-ний өдрийн хуралдаанаар тус асуудлыг хэлэлцээд "МУ-ын Засгийн газраас санаачлан боловсруулж 2021.11.24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг татан авахаар тогтсон".	
72	1.3. Хүнд үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай ус хангамж, эрчим хүч, тээвэр ложистик зэрэг дэд бүтцийн төлөвлөлт, судалгаа боловсруулах.	Боловсруулсан судалгаа, баримт бичгийн тоо	1	4	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Таван толгойн нүүрсний ордыг түшиглэн байгуулах үйлдвэрүүдийн ус хангамжийг газрын доорх усаар хангах ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, ус хангамжийн II шатны төсөл буюу "Загийн усны ус татах шугам хоолой"-н төслийг эхлүүлж, төслийн бүтээн байгуулалтын ажил 2024.12.31-ний өдрийн байдлаар 98%-тай байна.	50
73	1.4. Хүнд үйлдвэрийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, холбогдох бусад журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах.	Боловсруулсан журмын тоо	1	4	Улсын төсөв, зээл, тусламж	"Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам"-ыг БШУСайд, УУХҮСайд, ХХААХҮСайдын "Журам батлах тухай" 2021.11.08-ны өдрийн А/381 / А/274/А-313 дугаар хамтарсан тушаалаар батлуулан. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5553 дугаарт бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актыг УУХҮЯ-ны цахим хуудсанд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээ тогтоох аргачлалыг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайд болон ХХААХҮСайдын хамтарсан тушаалаар 2022.06.22-нд батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5874 дугаарт бүртгүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.09.22-нд батлуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн	30

							бүртгэлийн 5959 дугаарт бүртгүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн сан үүсгэх, бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам”-ыг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 6505 дугаарт бүртгүүлсэн. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцад дээрх мэдээллийн сангийн программ хангамжийг гүйцэтгүүлэх зардлыг тусгуулахаар 2024 оны 05 болон 10 дугаар сард тус тус санал хүргүүлсэн. Улмаар АҮЭБ-ийн сайдын 2025 оны төсвийн санал (эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал)-д Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн сангийн программ хангамжийг боловсруулахад шаардагдах зардал тусгагдан батлагдсан байна.	
Үндсэн чиг үүрэг-2: Тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах замаар хүнд үйлдвэрийг хөгжүүлэх.								
74	Зорилт-2: Хүнд үйлдвэрлэлийг цогцолбороор хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгоно.	2.1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл/	“Эдийн Засгийн Хөгжлийн Яам” /хуучнаар/ нь “Кью Эс Си” ХХК-тай 2014 онд байгуулсан “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг ЗГ-ын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор цуцалсан. Уг тогтоолын дагуу ТӨБЗГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн өмчит компанийн статустай болгож, бүтцийг баталж, удирдлагыг томилсон. 2020-2023 онуудад Дарханы төмөрлөгийн үйлдвэр нь гангийн үйлдвэр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ, БОННУ, Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн цахилгаан хангамжийн горимын тооцоо, төслийн газар шорооны тэгшилгээний ажил, төмрийн хүдрийн туршилт, “Монгол ган цогцолбор I” төслийн 3D макет хийлгэх зэрэг нилээлгүй ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Толгой компани буюу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.10.22-ны өдрийн “Чиглэл өгөх тухай” 01/836 дугаар албан бичгийг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д ирүүлсэн ба “Монгол ган цогцолбор I” төслийн концепци, хүчин чадлыг өөрчлөн 1 сая тн бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэлийг өгсөн тул өмнө хийгдсэн ТЭЗҮ, БОННУ, бусад судалгааны ажлуудыг шинэчлэн хийх шаардлагатай болсон.	30

						Шинэ төслийн хүрээнд 2024 онд дараах ажлууд хийгдсэн. 1. Дархан УТП байгуулах хүрээнд: - Паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан. - Паркийн газрын сонголтыг /950 га/ хийж газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах хүсэлтийг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлж өгөх хүсэлтийг АҮЭБСайдын 2024.12.03-ны өдрийн 01/1184 дүгээр албан бичгээр ЗГХЭГ-ын даргад хүргүүлсэн. 2. Шууд агижруулсан төмөр /ШАТ/-ийн үйлдвэр байгуулах ажлын хүрээнд: - ШАТ-ийн үйлдвэрийн ТЭЗҮ болосвруулж 2024.06.22-ны өдөр батлуулсан. 3. Нойтон баяжуулах, хорголжийн үйлдвэр байгуулах ажлын хүрээнд: - ТЭЗҮ-ийн ажлын даалгавар боловсруулсан. - Түүхий эдийн туршилтын ажил хийгдэж байна. 4. Жилд 1 сая тонн хүчин чадалтай Гангийн үйлдвэр байгуулах ажлын хүрээнд: - Төслийн концепцийн судалгаа хийгдсэн - Түүхий эдийн туршилт хийгдэж байна. - Төслийн ТЭЗҮ-ийн ажлын даалгаврыг боловсруулсан. 2025 онд цогцолборын үйлдвэрүүдийн ТЭЗҮ, судалгааны бусад ажлуудыг хийж дуусгах, 2026 оноос бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.	
75		2.2.Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	75.8 хувь	100 хувь	Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл/ Бэрэн групп ХХК-ны 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдэгдээгүй байгаа ба Хөгжлийн банкны зээл, өрийн асуудлаар “Бэрэн групп” ХХК-ийг хууль хяналтын байгууллагаас шалгаж, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон ба 2023 оныг дуустал хугацаанд (одоог хүртэл 2024.12.31) төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх, бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх талаар аливаа үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.	-

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

76		2.3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	16.4 хувь	100 хувь	Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт/	Үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмж (нийт 2.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий тус бүр нь 2 тн багтаамжтай 6 ш индукцийн зуух, дулаан боловсруулалтын 1 ш зуух дагалдах хэрэгслийн хамт)-ийн захиалга /БНХАУ "Qianxi ADI Machanical Casting" Co.Ltd компанид/ хийгдэж, 2023 оны 10 дугаар сард татан авалтыг хийсэн ба угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэсэн. 2024 оны 5 дугаар сарын байдлаар дулаан боловсруулалтын зуухны угсралтын ажил, цутгуурын цехийн төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж, ашиглалтад оруулсан. 1.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 6 кВ-ын 1.2 км ЦДАШ-ыг 2024 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмжийн угсралтийн ажлыг 2024 оны 5 дугаар сард хийж дуусгасан ба туршилт, тохируулгын ажлыг 2024 оны 06 сараас хийж, 10 дугаар сард бүрэн ашиглалтад оруулсан.	100
77		2.4. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах /"Болдтөмөрөрөөгол" ХХК/.	Үйлдвэр байгуулах ажлын явц	20 хувь	80 хувь	Хувийн хөрөнгө оруулалт	"Инфинити спейс" ХХК Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт нийт 140 га талбайд "Алтанширээт үйлдвэрлэл, технологийн парк" байгуулах төслийг 2019-2028 онд хэрэгжүүлэн ажиллаж байна. Цогцолборын хэмжээнд 500 мянган тонн хүчин чадалтай ширэмний үйлдвэр бүхий 5 үйлдвэр байгуулагдах ба эхний 4 үйлдвэр нь ширэмний үйлдвэрээ түүхий эдээр хангах зорилготой. Засгийн газрын 2023.07.05-ны өдрийн 257 дугаар тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. 2024 оны 12 дугаар сарын байдлаар 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 12 км төмөр зам, усан хангамжийн нэгдсэн сүлжээ, паркийн усан хангамжийг шийдэх зорилгоор Бор хөөвөр болон Долоодын говиос гүний ус дамжуулах 103 км урттай шугамын трассын зураглал, нүүрс болон төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил тус тус 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Коксын үйлдвэрийн бүтээн байгуулалт, эрчим хүчний эх үүсвэрийн барилгын ажил 55 хувь, төслийн нийт гүйцэтгэл 65%. "Инфинити спейс" ХХК-ийн татвар төлөх хугацааг Засгийн газрын 2024.05.01-ний өдрийн 191 дугаар тогтоолоор сунгасан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яам, "Инфинити спейс" ХХК-ийн хооронд үйлдвэрлэл, технологийн паркийн төсөлд ашиглах импортоор оруулах барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан	70

							татварыг 4 жил хүртэл хугацаагаар сунгах гурван талт 188/50/25 дугаар бүхий гэрээг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан.	
78		2.5. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	5 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл	Үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмж (нийт 2.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий тус бүр нь 2 тн багтаамжтай 6 ш индукцийн зуух, дулаан боловсруулалтын 1 ш зуух дагалдах хэрэгслийн хамт)-ийн захиалга /БНХАУ “Qianxi ADI Machanical Casting” Co.Ltd компанид/ хийгдэж, 2023 оны 10 дугаар сард татан авалтыг хийсэн ба угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэсэн. 2024 оны 5 дугаар сарын байдлаар дулаан боловсруулалтын зуухны угсралтын ажил, цутгуурын цехийн төхөөрөмжийн угсралтын ажил хийгдэж, ашиглалтад оруулсан. 1.1 тэрбум төгрөгийн өртөгтэй 6 кВ-ын 1.2 км ЦДАШ-ыг 2024 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. Үйлдвэрийн цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн тоног төхөөрөмжийн угсралтийн ажлыг 2024 оны 5 дугаар сард хийж дуусгасан ба туршилт, тохируулгын ажлыг 2024 оны 06 сараас хийж, 10 дугаар сард бүрэн ашиглалтад оруулсан. Хэрэгжилт 100 %. ҮТП-ийн дэд бүтцийн ажлын явц: - Авто зам барьж байгуулах ажлын Багц-2 буюу автозамын гэрэлтүүлэг барьж байгуулах тендерт "Оркон тех" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Ажлын явц 30%. Гэрээний хугацаа 2024.11.01-нд дууссан ба автозамын барих ажлын гүйцэтгэлээс шалтгаалан гэрээг 2025.12.15 хүртэл сунгасан. Багц-1 буюу автозам барьж байгуулах ажлын тендерт "Шилдэг зам" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2024.11.01-нд дууссан. Хайрга, чулууг буталж, шигших, далангийн дүүргэлт, усалгаа, арчилгаа, хөлдөлтөөс хамгаалах үеийн дүүргэлт, үерийн ус зайлуулах дөрвөлжин болон дугуй хоолой угсралт, хоолойн буцаан дүүргэлт хийгдсэн. Асбальт хучилтын ажил 2025 онд хийгдэнэ. Ажлын гүйцэтгэл 51%. Автозамын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендер "Мөнхөд ашдын зам" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. - Төмөр зам барьж байгуулах ажлын тендерт /2022 он/ "Туулын гүүр далай" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2023.12.31-нд дууссан. Ул хөрсний төлөвлөгдөөгүй нэмэлт ажил болон цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний хугацаанд ажил гүйцэтгэх боломжгүй болж, гэрээг 2024.10.15 хүртэл сунгасан. Төмөр замын зохиогчийн хяналтын гэрээг "Максимал" ХХК-тай, Төмөр замын захиалагчийн	70

							хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээг "Рэйлвэй консалтинг Сервис" ХХК-тай байгуулан ажиллаж байна. Үерийн ус зайлуулах хоолойн угсралтын ажил, шаардлага хангахгүй хөрсийг ухаж сайн хөрсөөр солих ажил, ул хөрсний тэгшилгээ, нягтруулалт зэрэг ажлууд дууссан. Гэрээний хугацаа дууссан гүйцэтгэгч "Туулын гүүр далай" ХХК-ийн ажлын гүйцэтгэл удаашралтай байгаа ба 2024 оны 12-р сард дуусгахаар ажиллаж байна. Ажлын явц 96%. Төмөр замын 2-р ээлжийн буюу өртөөний хэсэг, 1-р ээлжийн замтай холбох хэсгийг 2025 оны ХО-ын төлөвлөгөөнд тусгуулан, тендер зарлах бэлтгэл ажил ханган ажиллаж байна. - Ус хангамж, ариутгах татуургын систем барих тендер "Б-софт" ХХК шалгарч, 2023.12.13-нд гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2024.12.20-нд дуусна. "Б-софт" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу ажлын хэсэг хуралдан Wilo брэндийн насос үйлдвэрлэл тээвэрлэлтийн хугацаанаас шалтгаалан удааширч байгаа, усан туршилтыг дулааны улиралд хийхтэй холбогдуулан 2025.06.30-ны өдөр хүртэл сунгасан. Ажлын явц 86%. - УТП-ын газрыг тойруулан хашаа барих ажлыг "Орчлонтулга" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Угсармал бетон болон бетон шонтой өргөст утсан нийт 16.3 км хашаа баригдана. Гэрээний хугацаа 2024.07.01-нд дууссан. УТП-ийн газрын хил заагийн давхцал зэргээс шалтгаалан тухайн хэсэгт баригдсан 1.7 км хашааг шилжүүлэн барьж 600 метр хашааг шинээр сунгаж барих уулын орой, өгсүүр хэсэгт 3.5 км бетон шонтой өргөст утсан хашаагаар сольж барих шаардлага үүсэн зэрэг шалтгаанаар гэрээг 2024.09.15 хүртэл сунгах санал ирүүлсэн, "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий инженерийн 2024.08.21-ний албан бичгээр гэрээг дахин сунгах боломжгүй талаар мэдэгдсэн. Ажлын явц удаашралтай хашааны 3,4-р үеийн хавтан угсрах ажил хийгдээгүй байна. Ажлын явц 92%.	
79		2.6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын УТП байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барих.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	95 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл	ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-ийг "ЭҮ" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан. - ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн	30

						үйлдвэрлэлийн бүсэд явуулсан. 2024.10.31-ны байдлаар туршилтын ажлыг дуусгасан. 2024 оны 12 дугаар сард туршилтын эцсийн тайлан гарна. Ажлын явц 90% - Тус үйлдвэрлэлийн туршилтын эцсийн үрд дүнгээр ТЭЗҮ-д тодотгол оруулах бөгөөд АҮЭБЯ-ны ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. - ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах" ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц 90% - Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг "ЭҮ" ТӨҮГ-ын Судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай гэрээ байгуулан ажиллаж, тайланг хүлээн авсан. - ЗБХБҮ-ийн БОННУ хийгдсэн. - ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ хийх ажлыг "Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв" ХХК гүйцэтгэж, эцсийн тайлан ирүүлсэн ба АҮЭБЯ-ны Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	
80	2.7. Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	100 хувь	Хувийн хөрөнгө оруулалт, зээл	"ЭҮ" ТӨҮГ нь "Майнинг Шорт Лонг Терм" ХХК-тай "SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээний гэрээг 2021.09.17-ны өдөр байгуулан ажиллаж байна. Тус үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2022 оны 6-р сарын 24-нд хэлэлцүүлж СТР/22-03-01 дугаар дүгнэлт гаргуулсан. "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөл 2022.10.13-нд хуралдаж "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "ЭҮ" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Гүйцэтгэгч ТЭЗҮ-ийг засварлан ЭҮ ТӨҮГ-ийн Техникийн зөвлөлийн 2023.02.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн тул УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хурлаар 2023 оны 4-р сарын 04-ны өдөр хэлэлцүүлж, ЭБМЗ-ийн 2023.04.04-ны өдрийн СТР/23-01-04 дугаар дүгнэлтээр дэмжигдэж, АМГТГ-ын даргын "Техник эдийн засгийн үндэслэл бүртгэх тухай" 2023.04.21-ны	30

						өдрийн Т/39 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-ийг хүлээн аваад байна. "ЭҮ"ТӨҮГ-ын 2022.12.09-ний өдрийн А/818 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2023.04.24-ний өдрийн хурлаас 1 болон 2-р шатны ажлыг нийт ажлын 63.8% гэж үнэлж санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. "ЭҮ" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны хуралдааны шийдвэрийн дагуу ТЭЗҮ-ийн дараагийн шатны ажил болох "Нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил"-ыг "Майнинг шорт лонг терм" ХХК-иар хийлгэх шаардлагатай эсэхийг техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, "ЭҮ" ТӨҮГ-ын 2023.06.02-ны өдрийн А/353 тоот тушаалаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгийн 2023 оны Х/05; Х/30; Х/22-ны өдрийн хурлаас нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэл хангалтгүй гэж дүгнэсэн. "ЭҮ" ТӨҮГ-ын дээд шатны удирдлагууд гүйцэтгэгч компанийн төлөөлөлтэй уулзаж гэрээний үүргээ биелүүлээгүйг анхааруулсан ба гүйцэтгэгч компанийн захирал хүлээн зөвшөөрч, тайлбарыг албан бичгээр ирүүлэхээ илэрхийлсэн. "SX/EW технологиор катодын зэс гаргах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" ажлын гүйцэтгэгч "Майнинг шорт лонг терм" ХХК-аас гэрээний хугацааг дуусгавар болгохыг хүссэн албан бичгийг 2024.03.06-ны өдөр "ЭҮ" ТӨҮГ-т ирүүлж, "ЭҮ" ТӨҮГ Хуулийн хэлтэс, ХОХААБГ тус асуудлыг судалж "гэрээг дуусгавар болгох саналыг хүлээж авсан тухай" албан бичгийг гүйцэтгэгчид 2024.04.29-нд хүргүүлж, гэрээг дүгнэж, цуцалсан. Исэлдсэн хүдрийг HL-SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын тендерт "Төгрөг баян хангай" ХХК шалгарч "ЭҮ" ТӨҮГ-тай 2023.10.26-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эцсийн тайланг 2024.04.20-ны өдөр ЭҮ ТӨҮГ-т хүлээлгэн өгсөн. Исэлдсэн хүдрийг HL-SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Техник, технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын гэрээг ШУТИС-ийн МТС-тай 2024.02.14-ний өдөр байгуулсан ба гэрээний дагуу 2024.06.14-ний өдрөөс өмнө тус ажлыг бүрэн дуусгахаар төлөвлөсөн боловч, хугацаандаа амжаагүй тул гэрээг 2024.12.01-ны өдөр хүртэл сунгаж, тайланг хүлээж авсан. АҮЭБЯ-ны ЭБМЗ-
--	--	--	--	--	--	--

							д тайланг хүргүүлж шинжээч томилж, холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	
81		2.8. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах.	Үйлдвэр байгуулах ажлын явц	0 хувь	100 хувь	Гадаадны шууд хөрөнгө оруулалт	Төсөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс алт ресурс” ХХК 2020-2021 онд олон улсын 20 гаруй компанитай холбоо тогтоож төсөл дээр санал авсан ба “түлхүүр гардуулах” нөхцөлөөр 4 компани (Сымбат инженеринг, Шинхай групп, “Кронимет Майнинг, Зижин Майнинг) санал ирүүлсэн. “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий” ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн дүгнэлтийг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 03/678 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн. Дүгнэлтээр: 1. ТЭЗҮ нь Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн үндэслэлийг тооцоогүй, эдийн засгийн тооцоолол бүхэлдээ буруу хийгдэж алдаатай болсон, төслийг хэрэгжүүлэх эрсдэлтэй тул дахин шинээр хийх; 2. “Сымбат инженеринг” ХХК-тай цаашид ажиллахгүй тохиолдолд төсөлд оролцохоор ирүүлсэн хамгийн сайнаар үнэлэгдэх санал болох БНХАУ-ын “Шинхай групп”-ийн саналтай дүйцэх саналыг хэрэгжүүлэх; 3. Цэвэршүүлэх алт мөнгөний жилийн хүчин чадлыг Монголбанкинд 1990 оноос хойш аж ахуй нэгж байгууллага, иргэдийн тушаасан алт мөнгөний хэмжээ, нөөц, уул уурхайн компаниудын хэтийн төлөв, ирээдүйд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөр, хэмжээ, нөөцийг харгалзан үзэж жилд 30 хүртэл тн алт, 50 хүртэл тн мөнгө цэвэршүүлэх, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх боломжтойгоор төлөвлөх; 4. Эдгээр хувилбаруудаас хамгийн боломжит хувилбар “Түлхүүр гардуулах” төсөл хэрэгжүүлэгчээр өөрөөр нь санхүүжих, 8-10 жилийн урт хугацааны гаднын банкны хөнгөлөлттэй зээлд хамрагдах хувилбарыг судлах гэсэн дүгнэлт гарсан. Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яаманд 2023.02.17-ны өдрийн 02/475 албан бичгээр БНКаЗУ-ын “Сымбат инженеринг” ХХК -тай цаашид баримтлах байр сууриа яамны зүгээс илэрхийлсэн. Төслийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй байна.	1-1
82		2.9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг	Үйлдвэр байгуулах ажлын явц	0.2 хувь	20 хувь	Гадаадын шууд	“Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл,	1-1

		боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх.				хөрөнгө оруулалт	холбогдох материалын хамт УУХҮ-ийн сайдын 2023.01.03-ны өдрийн 01/04 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023.01.11-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг татан буулгах, төслийн нэгжийн чиг үүрэг, холбогдох баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэхийг УУХҮ-ийн сайдад даалгасан. Уг тогтоолоор “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих” төслийн нэгжийг татан буулгасантай холбоотойгоор төслийн чиг үүрэг, баримт бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэх Ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2023.02.01-ний өдрийн А/08 дугаар тушаалаар байгуулж, уг төсөлтэй холбоотой бүх баримт, материалыг 2023.03.30-ны өдөр “Эрдэнэс Монгол” ХХК-д хүлээлгэн өгсөн. Мөн төслийн хүрээнд Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах урьдчилсан сонгон шалгаруулалтын болон Тендерийн баримт бичгийг боловсруулж санал авахаар Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022.12.21-ний өдрийн 01/3357 албан бичгээр хүргүүлсэн. Гэвч уг албан бичгийн хариу ирээгүй тул дахин санал авахаар УУХҮ-ийн сайдын 2023.06.05-ны өдрийн 01/1366 албан бичгийг хүргүүлсэн.	
5. Ерөнхий чиг үүрэг: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх.								
Үндсэн чиг үүрэг-1: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.								
83	Зорилт-1: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах.	1.1. Яамны дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах, тайлагнах.	Үйл ажиллагааны үнэлгээний хувь	92 хувь	95 хувь	Улсын төсөв	- Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2020-2024 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлыг тухай бүр хуулийн хугацаанд зохион байгуулж ажилласан.ТНБД-ын 2024.12.11-ний өдрийн А/74 дугаар тушаалаар байгуулсан салбарын болон яамны стратеги төлөвлөгөө боловсруулах, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан. ЗГҮАХ 2024-2028 хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталдан, албажиж ирээгүй тул АҮЭБС-аар баталгаажих ажил түр хугацаагаар хойшилсон. - УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд АҮЭБ-ийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг	100

							нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" АҮЭБ-ийн сайдын 2024 оны 12р-сарын 30-ний өдрийн 03/1455 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./ - УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан арга хэмжээг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" АҮЭБ-ийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 03/1456 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн./ - Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тусгагдсан УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын эрхлэх асуудлын хүрээний төслүүдийн 2020, 2021, 2022, 2023 ,2024 оны хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 03/1455 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./ - Улсын хөгжлийн 2020, 2022, 2023, 2024 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн. /2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 03/1455 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./ - АҮЭБ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд батлагдсан Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн (137 шийдвэрийн 241 зүйл, заалт) хэрэгжилтийн тайланг 2020-2024 оны байдлаар нэгтгэн сар бүр ХШҮДАГ-т хүргүүлсэн. /2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 03/1455 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./ - Гадаадын зээл тусламжаар хэрэгждэг төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг АҮЭБ-ийн сайдын 2024 оны 12 дугаар сарын байдлаар Сангийн яаманд хүргүүлсэн./	
Үндсэн чиг үүрэг-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах зохион байгуулах.								
84	Зорилт-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй	2.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийн стратегийн баримт	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	"Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх" хөтөлбөрийн Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/128 дугаар тушаал баталсан. Үүний дагуу жил бүр сургалтын хөтөлбөрийг	100

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

	боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах.	бичгийн төслийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.					хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
Үндсэн чиг үүрэг-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн талаар олон нийтэд сурталчилан таниулах.								
85	Зорилт-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулах, өргөн барихад дэмжлэг үзүүлэх.	3.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах.	Боловсруулсан хууль тогтоомж, эрх зүйн актын тоо	108	112	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	- Геологи, уул уурхайн салбарын эрх зүйн орчинтой холбогдуулж, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2021.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар батлагдсан "МУ-ын Ерөнхий сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын 12.8-д заасан Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах, хүнээс хамааралгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээний хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох нөхцөл боломжийг судлах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллан, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.04.12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар "Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам"-ыг батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5821 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов. - Геологийн бодлогын газраас боловсруулсан Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянаж, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ Сайдын 2022.05.02-ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5828 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов. - СХОГ-аас боловсруулан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангийн дараах захиргааны статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ Сайдын 2022.05.31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5852 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов. - Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын	100

						төслийн боловсруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны дэд ажлын хэсэгт ажиллан 2022.06.15-ны өдөр Үйлдвэржилтийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлж Улсын Их Хурлын 2022.06.16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн. Тус хууль нь 2022.07.05-ны өдөр батлагдаж, 2022.08.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. - Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж хуулийн төслийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. - Хүнд үйлдвэрийн газраас боловсруулан УУХҮС, БСШС, ХХААХҮС нартай хамтран баталсан "Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох" журмыг батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5553 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов. - Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс санал авахаар ГТБГ-ын Даргын 2021.09.09-ний өдрийн 08/2198 дугаар албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулсан. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг судалгааны тайлангуудыг тус тус боловсруулсан. Тус хуулийн төслийг 2022 оны УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022 оны А/44 дүгээр тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр
--	--	--	--	--	--	--

						дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч, саналын товьёг нэгтгэсэн. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-ын чуулганаар хэлэлцэн дэмжигдэж, батлагдаад байна. - ГТБГ-аас боловсруулсан Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага болон тайлангийн хүснэгтийн загварын төслийг хуулийн хүрээнд хянаж, засаж сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянаж, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.11.16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 6017 дугаарт бүртгүүлэв. - ГТБГ-аас боловсруулсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн төслийг хуулийн хүрээнд хянаж, засаж сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.11.16-ны өдрийн А/288 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 6018 дугаарт бүртгүүлэв. ХҮБГ-аас боловсруулсан Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн төслийг хуулийн хүрээнд хянаж, засаж сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.09.22-ны өдрийн А/245 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 5959 дугаарт бүртгүүлэв. - ХҮБГ-аас боловсруулсан Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журмын төсөл, Технологийн түвшний үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалын төслийг хуулийн хүрээнд хянаж, засаж сайжруулан Захиргааны ерөнхий хуульд
--	--	--	--	--	--	---

						заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022.06.22-ны өдрийн А/135/А/200 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 5874 дугаарт бүртгүүлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10.1, 16.2-т зааснаар “Монголын хөрөнгийн бирж” ХК (МХБ)-ийг уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. - Монгол Улсын Засгийн газраас Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгаж, чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх болсонтой холбогдуулан Засгийн газрын 2022 оны 469 дүгээр тогтоолын 4 дэх заалтаар “энэ тогтоол гарсантай холбогдуулан яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, батлуулах”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад даалгасан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц орон тооны хязгаар батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолын хавсралтад салбарын хяналтын чиглэлээр нэмэлт, өөрчлөлтийг оруулж Засгийн газрын тогтоолын төслийг батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 466 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам”-ыг боловсронгуй болгох хүрээнд “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийн боловсруулж батлуулсан. - УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны А/316 дугаар тушаалаар байгуулагдсан Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан. - Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд нар хамтран баталж,	
--	--	--	--	--	--	---	--

							Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-аар батлуулсан. - Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг тус тус соёрхон батлах тухай хуулийн төслүүдийг боловсруулахад хууль зүйн техникийн дэмжлэг үзүүлж Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024.11.29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, соёрхон батлуулсан. - ХЗДХЯ-аас ирүүлсэн 2024.01.05-ны өдрийн 01/6470 дугаартай албан бичгийн дагуу Захиргааны хэм хэмжээний актыг хуульд нийцүүлэн боловсруулах болон холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг ТНБД-ын 2024.01.05-ны өдрийн 03 дугаартай тушаалаар батлуулан ажилласан. - Засгийн газрын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ сайд болон Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарын хооронд байгуулах Хамтран ажиллах гэрээний төслийг хянасан.	
Үндсэн чиг үүрэг-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.								
86	Зорилт-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээний талаар гадаад орон, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх.	4.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хоёр болон олон талт хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулах.	Байгуулсан гэрээ, хэлэлцээрийн тоо	3	7	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Салбарын гадаад хамтын ажиллагааны хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: - УУХҮЯ /хуучин нэрээр/ болон БНСУ-ын Геологи, эрдэс баялгийн хүрээлэн хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийг 2022.05.31-ний өдөр Улаанбаатар хотноо байгуулсан. - Монгол Улс Үндэсний геологийн алба, Бүгд Найрамдах Польш улсын Геологийн хүрээлэн-Үндэсний судалгааны хүрээлэн хооронд байгуулах хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан 2021.11.24-ний өдөр Санамж бичгийг Улаанбаатар хотноо байгуулсан. - “Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Байгалийн нөөц, баялгийн яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг 2022.11.1.25-ны өдөр цахимаар байгуулав. - Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын ахалдаг “Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан Зөвлөлийн анхдугаар	100

						хуралдааныг 2021 оны 10-р сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан. - “Монгол Улсын УУХҮЯ /хуучин нэрээр/ болон БНСУ-ын Геологи, эрдэс баялгийн хүрээлэн хооронд хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг 2022.05.31-ний өдөр байгуулав. - “Техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын УУХҮЯ, БНСУ-ын Газрын тосны чанар, хангамжийн газар хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг 2022.08.10-ны өдөр байгуулав. Санамж бичгийн хүрээнд газрын тосны чанар хангамжийн асуудлаар УУХҮЯ болон АМГТГ-ын холбогдох төлөөлөгчид тухай бүр БНСУ-д айлчилж уулзалтуудыг хийж, сургалт зохион байгуулсан. - “Ховор метал нийлүүлэх сүлжээнд хамтран ажиллах тухай Монгол Улсын УУХҮЯ болон БНСУ-ын Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг 2023.02.15-ны өдөр Сөүл хотноо байгуулж гарын үсэг зурсан. Санамж бичгийн хүрээнд “Монгол, Солонгосын ховор металлын хамтарсан судалгааны төв”-ийг байгуулж тус төвийг тоног төхөөрөмжөөр хангах ажлыг Сангийн яамтай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр “Монгол, Солонгосын хамтарсан хороо”-ны анхдугаар хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулж хамтарсан хорооны бүтэц, үйл ажиллагааны чиглэлийг тохиролцсон. - “Уул уурхай, эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын УУХҮЯ /хуучин нэрээр/ болон Бүгд Найрамдах Чех Улсын Үйлдвэр, худалдааны яам хоорондын хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг 2023.05.12-ны өдөр байгуулсан. - “Монгол Улсад ховор металлын чиглэлээр хамтран ажиллах тухай ИБУИНХУ-ын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн яам болон Монгол Улсын УУХҮЯ /хуучин нэрээр/ хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг 2024.04.25-ны өдөр байгуулав. - “Эрдэс баялгийн салбарын хөгжил, засаглалын чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын УУХҮЯ /хуучин нэрээр/ болон АНУ-ын Төрийн департамент хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийг 2023.06.27-ны өдөр байгуулсан. Энэ хүрээнд Монгол-БНСУ-АНУ-ын 3 талт уулзалтыг 2023.06.27-ны өдөр ГХЯ-тай хамтран зохион байгуулав.
--	--	--	--	--	--	--

							- Канадын хайгуулч, олборлогчдын холбооноос зохион байгуулдаг “Олон улсын уул уурхайн чуулга уулзалт (PDAC)” арга хэмжээнд жил бүр сайдын түвшинд оролцох бэлтгэл ажлыг хангаж, Монгол Улсын эрдэс баялгийн салбарыг гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчлах, Засгийн газраас уул уурхайн салбарт хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрүүдийг танилцуулах зорилгоор “Monoglia Day” арга хэмжээг 2021, 2022, 2023, 2024 онуудад Канадын Торонто хотноо зохион байгуулсан. Мөн Олон улсын уул уурхайн сайд нарын дээд хэмжээний уулзалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд оролцож хамтын ажиллагааны асуудлаар санал солилцох уулзалтуудыг хийв. - Австралийн Сидней хотод зохион байгуулдаг Олон улсын эрдэс баялгийн чуулга уулзалт (IMARC) -д жил бүр сайд, Төрийн нарийн бичгийн даргын түвшинд оролцож Австралийн болон тус чуулга уулзалтад оролцогч бусад улсын уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчид, төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөгчдөд Монгол Улсын уул уурхай, эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах боломжуудын талаар холбогдох уулзалтуудыг зохион байгуулав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ сайд, удирдлагуудын зүгээс Монгол Улсад суугаа бусад орны Элчин сайд, ОУБ-ын тэргүүнүүд, мөн гадаад орны эрдэс баялгийн сайдууд, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын удирдлагуудтай хийх уулзалтуудыг тухай бүр зохион байгуулж, хоёр орны уул уурхайн салбарын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцсон. Түүнчлэн хоёр орны Засгийн газар хоорондын комиссуудын хуралдаан, хамтарсан хороо, зөвлөлдөх уулзалтуудад салбар яамны зүгээс хүргүүлэх санал болон яамны төлөөлөгчдийг тухай бүр оролцуулах бэлтгэл ажлыг хангав.	
Үндсэн чиг үүрэг-5: Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх.								
87	Зорилт-5: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын	5.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (ТЕЗ)-ын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах.	Боловсруулсан төсвийн төслийн тоо	1	4	Улсын төсөв	Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсөөллийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023.08.15-ны өдрийн 01/0975 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлж, Сангийн	100

	удирдамжаар хангах, сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулж, үйлчилгээ үзүүлэх.						яамны Төсвийн бодлогын газартай холбогдож тайлбар үндэслэлээр ханган ажилласан. 2024 оны төсвийн тухай хуулиар УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2024 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 421.9 тэрбум төгрөгөөр, зарлагыг 59.9 тэрбум төгрөгөөр тус тус баталсан. Үүнээс урсгал зардалд 19.9 тэрбум төгрөг, геологи хайгуул судалгааны зардалд 40.0 тэрбум төгрөг батлагдсан. 1. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцын 2023 оны төсвийн зардлыг 41.7 тэрбум төгрөгөөр баталсан. 2.УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцад 2023 онд батлагдсан 41.7 тэрбум төгрөгийн зардлаас 38.9 тэрбум төгрөгийн буюу 93.2% гүйцэтгэл хийгдсэн байна. 3.УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцаас 2023 онд төвлөрүүлэхээр баталсан 485.8 тэрбум төгрөгөөс 402.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж 82.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын Төсвийн тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсөөллийг УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2024.07.25-ны өдрийн 01/17 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамны Төсвийн бодлогын газартай холбогдож тайлбар үндэслэлээр ханган ажилласан. 2025 оны төсвийн тухай хуулиар УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2025 оны төсөвт төвлөрүүлэх орлогыг 407.3 тэрбум төгрөгөөр, зарлагыг 48.9 тэрбум төгрөгөөр тус тус баталсан. Үүнээс урсгал зардалд 27.9 тэрбум төгрөг, геологи хайгуул судалгааны зардалд 20.0 тэрбум төгрөг батлагдсан. 1. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцын 2024 оны төсвийн зардлыг 61.7 тэрбум төгрөгөөр баталсан. 2.УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцад 2024 онд батлагдсан 61.7 тэрбум төгрөгийн зардлаас 38.9 тэрбум төгрөгийн буюу 93.2% гүйцэтгэл хийгдсэн байна. 3.УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцаас 2023 онд төвлөрүүлэхээр баталсан 291.9 тэрбум төгрөгөөс 216.7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж 74.2%-ийн гүйцэтгэлтэй байна.	
--	---	--	--	--	--	--	--	--

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

88	5.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (ТЕЗ)-ын төсвийн багцын санхүүгийн тайланг нэгтгэн баталгаажуулах, тайланг холбогдох газарт хүргүүлэх.	Хүргүүлсэн тайлангийн тоо	1	4	Улсын төсөв	1. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулж хуулийн хугацаанд Үндэсний аудитын газар хүргүүлэн дүгнэлт гаргуулж 2021.04.25-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгүүлсэн. 2. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан болон сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд өгсөн акт, албан шаардлагын зөвлөмжийн биелэлтийг 2023 оны гуравдугаар улирлын байдлаар гарган хавсралтаар хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт 90.7%, акт, албан шаардлагын биелэлтийг 87.4%-тайгаар хүргүүлсэн. 3. 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2024.08.25-нд гарган Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн. 4. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулж хуулийн хугацаанд 2024.04.05-нд Үндэсний аудитын газар хүргүүлэн 2024.04.25-нд дүгнэлт гаргуулж Сангийн яаманд хүргүүлсэн. Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгүүлсэн. 5. УУХҮЯ-ны ТНБДаргын 2024.10.04-ны өдрийн 03/592 дугаар албан бичгээр УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан болон сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд өгсөн акт, албан шаардлагын зөвлөмжийн биелэлтийг 2024 оны гуравдугаар улирлын байдлаар гарган хавсралтаар хүргүүлсэн. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 91.7 хувийн биелэлттэй, төсвийн шууд захирагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 95.0 хувьтай, УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын биелэлтийн хувь 86,4 хувьтай байна. 6. 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2024.08.25-нд гарган Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн.	100
89	5.3. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах, Төсвийн	Хүргүүлсэн тайлангийн тоо	1	4	Улсын төсөв	1.УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцын хэмжээнд 2021 онд 3 байгууллагын 23.9 тэрбум төгрөгийн 30 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөн ажилласнаас 22.5 тэрбум төгрөгийн 30 төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан. - Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн	100

		тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж ажиллах.				өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцын 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд ТНБДаргын 2022.01.14-ны өдрийн 03/99 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцын хэмжээнд 3 байгууллагын 31.8 тэрбум төгрөгийн 40 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөн ажилласнаас 31.5 тэрбум төгрөгийн 40 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. - УУХҮЯ-ны болон сайдын багцын худалдан авах ажиллагааны тайланг 2022 онд мэдээллийг сар бүр буюу 12 удаа Шилэн дансанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. - Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцын 2022 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд 2023.01.15-ны өдрийн дотор Сангийн яаманд хүргүүлсэн 3. УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын багцын хэмжээнд 2023 онд нийт 3 байгууллагын 9.1 тэрбум төгрөгийн 49 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөн ажилласнаас 8.4 тэрбум төгрөгийн 49 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. -УУХҮЯ-ны болон сайдын багцын худалдан авах ажиллагааны тайлан мэдээллийг сар бүр буюу 12 удаа Шилэн дансанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. -Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу УУХҮ-ийн сайдын багцын 2023 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд буюу 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/92 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 4. АҮЭБ-ийн сайдын багцын хэмжээнд 2024 онд 4 байгууллагын 32.6 тэрбум төгрөгийн 53 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөн ажилласнаас 32.0 тэрбум төгрөгийн 44 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.	
--	--	--	--	--	--	---	--

							-АҮЭБ-ийн сайдын болон сайдын багцын худалдан авах ажиллагааны тайлан мэдээллийг сар бүр буюу 12 удаа Шилэн дансанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. -Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу АҮЭБ-ийн сайдын багцын 2024 оны худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд цахим системээр илгээсэн бөгөөд 2025.01.15-ны өдрийн 01/110 тоот албан бичгээр Сангийн яаманд мөн хүргүүлсэн болно.	
6. Ерөнхий чиг үүрэг: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого, чиглэлийг тодорхойлох болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах.								
Үндсэн чиг үүрэг-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ажлыг зохион байгуулах.								
90	Зорилт-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр, зөвлөмжийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх.	1.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулахтай холбоотой хууль тогтоомж, хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Батлагдсан хууль тогтоомжийн тоо Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	1 0	3 2	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/65 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсгийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийг шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон бусад хуулиудтай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгон хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хууль хоорондын уялдааг сайжруулах зарчимд нийцүүлсэн. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар эдийн засаг, үйл ажиллагааны уялдааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах болон хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, урамшуулал үзүүлэхэд чиглэсэн зохицуулалтууд тусгагдсан. Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар шинэчлэн байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны төлөөлөл оролцож хуулийн төслийг бусад хуулиудтай нийцүүлэх, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох зарчим баримталсан. Өмнө нь хийгдсэн хөрөнгө оруулалтыг хадгалан үлдээх, үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн болон үйл ажиллагааны уялдааг хангах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг тусгасан. Хөрөнгө оруулалтын таатай, тогтвортой орчинг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдад татварын таатай	30

						орчин /хөнгөлөлт, урамшуулал/ — бүрдүүлэхэд анхаарсан.	
91	1.2. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн (тодотгол) төслийг боловсруулах, хөтөлбөрт туссан төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	Боловсруулсан хөтөлбөрийн (тодотгол) тоо	1	3	Улсын төсөв	Салбарын хэмжээнд хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад дараах бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Тухайлбал: - Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Олборлох салбарын засаглалыг сайжруулах төсөл (ТА-9752 MON)”, “Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT)”, “Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр 2 (AMEP-2)”-ийн хэрэгжилтийн тайланг нэгтгэсэн. - “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын шинэчилсэн төсөлд саналыг холбогдох газарт хүргүүлсэн. - “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний төсөлд уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын чиглэлээр тусгах саналыг нэгтгэн боловсруулж 2023 оны 01/774 дугаар албан бичгээр Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. - УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын Канад Улсын “Олон улсын уул уурхайн чуулга уулзалт (PDAC-2023)-д оролцох үеэр хийх уулзалт, ярианы сэдэвт салбарын хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар танилцуулга, мэдээллийг хүргүүлсэн. - Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны хуралдаанд танилцуулахтай холбогдуулан тайлбар, мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн. - Салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан. - Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ сайдын эрхлэх асуудлаар тусгах төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, ЭЗХЯ-нд хүргүүлсэн ба 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. - Хөрөнгө оруулалт шаардлагатай ашигт малтмалын ордуудын нөөц, шаардлагатай хөрөнгө оруулалт, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамж, төслийн үр ашиг зэрэг техник, эдийн засгийн голлох үзүүлэлтийн талаар мэдээллийг бэлтгэж холбогдох байгууллага танилцуулж, мэдээлэл хийсэн. - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ, олон улсын уул уурхайн салбарт мөрдөж	100

						байгаа хуулиудыг өөрийн орны эрх зүйн орчин, бүс нутгийн онцлогтой харьцуулсан судалгаа, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжүүлгэд ногдуулах албан татварын хувь хэмжээг оновчтой тодорхойлоход чиглэсэн тооцоо, судалгааг хийсэн. Ашигт малтмал, газрын тосны газраас “Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны судалгаа” боловсруулсан нь Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг шинэчлэхэд чухал алхам болсон. - Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгсөн. - Хөрөнгө оруулалт шаардлагатай ашигт малтмалын ордуудын нөөц, шаардлагатай хөрөнгө оруулалт, улсын төсөвт төвлөрүүлэх татвар, хураамж, төслийн үр ашиг зэрэг техник, эдийн засгийн голлох үзүүлэлтийн талаар мэдээллийг бэлтгэж холбогдох байгууллага /ЗГХЭГ, ЭЗХЯ, СЯ, Монголбанк/-д танилцуулсан. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд дараах төслийн хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Үүнд: - Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл; - “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “Ил уурхайн олборлолтын технологи нэвтрүүлэх төсөл”, “Далд уурхайн төсөл”, “Ус хангамжийн системийн төсөл”, “Нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл”; - Эрдэнэт гангийн үйлдвэр байгуулах төсөл; - Дархан гангийн үйлдвэр байгуулах төсөл; - Алтанширээт аж үйлдвэрийн парк байгуулах төсөл; - Газрын тос дамжуулах хоолой барих төсөл; - “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл”, “Исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл”, “Уул уурхай-металлург-химийн үйлдвэрлэлийн төсөл”; - Оюутолгойн ордыг түшиглэн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих” зэрэг төсөл болно. Салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгах төсөл, арга хэмжээний саналыг 2024 оны 01/162 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн ба 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Биелэлт 100 хувь
--	--	--	--	--	--	---

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

92	Зорилт-2: Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах.	2.1 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг тодорхойлох, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	1	3	Гадаадын зээл, тусламж	1. Монгол Улс-Герман Улсын хамтын ажиллагааны хүрээнд “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ ТД 2020.2036.0” төсөл 2022 оны 4 дүгээр сараас эхлэн тус яаманд хэрэгжиж байна. Хоёр тал харилцан тохиролцож, төсөл хэрэгжүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан төслийн хугацааг 2023.12.31-ний өдөр хүртэл байсныг 2025.03.31-ний өдөр, санхүүжилт 2,000,000 евро байсныг 2,550,000 сая евро болгон өөрчилсөн. Гэрээний хавсралтыг англи, монгол хэл дээр боловсруулан удирдлагад танилцуулж, 2023.11.27-ны өдөр ТНБД гарын үсэг зурж баталгаажуулсан. Энэхүү төслийг Германы талаас Холбооны геологийн шинжлэх ухаан, байгалийн нөөцийн газар (BGR), Монголын талаас УУХҮЯ, АМГТГ, ҮГА хамтран хэрэгжүүлж байна. Төслийн зорилго нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд уул уурхайн салбарын ил тод, үр дүнтэй засаглалыг дэмжихэд орших бөгөөд дараах үр үйл ажиллагааны дараах үндсэн гурван чиглэлтэй. Үүнд: -Зорилт 1: Монгол Улсын цахим засаглалын бодлогод нийцүүлэн ашигт малтмал, түүний олборлох салбарын цахимжуулалтыг дэмжих. Зорилт 2: Хамтрагч байгууллагуудын ажил үүргийн зохицуулах, хяналт явуулах хэрэгцээнд суурилсан арга барил, аргачлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Зорилт 3: Чадавхыг хөгжүүлэх. Төслийн 2025 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023.08.04-ний өдөр УУХҮЯ-ны /хуучин нэрээр/ ТНБД, АМГТГ-ын дарга болон ҮГА-ны дарга нар баталж төлөвлөгөөний дагуу ажилласан. 2. Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг бэхжүүлэх (TF0B8169)” төслийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах томоохон ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: -Монгол Улсын ОУИТБС-ын нэтгэл тайланг гаргах ажлыг зохион байгуулж, хэвлэн нийтлүүлсэн. 2022 онд олон улсын Баталгаажуулалтад оролцож, 70 оноо авж, стандартыг дунд түвшинд хэрэгжүүлсэн дүнг авсан. ОУИТБС-ын тайлагналын маягыг 2 удаа стандартын дагуу шинэчлэн батлуулсан. Компани, төрийн байгууллагуудын ОУИТБС-ын жил бүрийн тайланг гаргуулсан.	100
----	--	---	-------------------------------------	---	---	------------------------	--	-----

						-Цахим сургалт, бүсийн чуулган, хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн, Дэд зөвлөлийн үйл ажиллагааны сэргэлт зэрэг харилцаа холбоо мэдээллийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. -Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн төслийг боловсруулж бэлэн болгосон. Хуулийг төслийг өргөтгөж, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын хуулийн төсөл болгож, ХЗДХЯ-д шилжүүлэх ажлыг зохион байгуулсан. Санхүүжилт 2023 онд дуусгавар болсон. 1. Эдийн засаг, хөгжлийн яам болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Азийн хөгжлийн банктэй хамтран “Уур амьсгалын өөрчлөлт ба ухаалаг уул уурхай” төслийг хэрэгжүүлэхээр 2023.12.11-ний өдөр талууд санамж бичигт гарын үсэг зурж баталгаажуулсан. Энэхүү хүрээнд тус төслийг амжилттай хэрэгжүүлэхэд АХБ-аас Зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх фирмийн тендерийн сонгон шалгаруулалтыг зарлаж “Нова Терра” ХХК болон “Энержи маркетс групп” ХХК-иуд тус тус сонгогдсон. Төсөл 2024 оны 4 сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2026.06.30 хүртэл үргэлжлэх юм. “Нова Терра” ХХК болон “Энержи маркетс групп” ХХК АХБ-тай байгуулсан гэрээний дагуу ажиллаж байна. Төслийн зорилго: Монгол Улсад экспортод чиглэсэн нүүрстөрөгчийн хий багатай үйлдвэрүүд, тэр дундаа сэргээгдэх эрчим хүчний технологийн үйлдвэрлэлд шаардлагатай газрын ховор элементийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Техникийн туслалцааны төслийн зорилт нь нүүрстөрөгч бага ялгаруулдаг аж үйлдвэрийн стратеги, төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээл, боломжуудыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг арилгахад шаардлагатай бодлогын багц шинэчлэлийг санал болгох, Засгийн газарт бодлогын баримт бичиг гаргахад дэмжлэг үзүүлж, судалгааны баримт бичиг боловсруулах; Цаг уурын өөрчлөлт, дэлхий нийтээр ногоон эдийн засагт шилжиж буй энэ үед шаардлагатай чухал ашигт малтмал болон бусад металлуудад төвлөрсөн аж үйлдвэрийг бий болгоход оролцогч талуудын дэмжлэгийг бий болгох юм. Хүрэх үр дүн: Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ухаалаг уул уурхайн стратеги, газрын ховор элементийн талаар баримтлах бодлогын баримт бичигтэй болсон байна.
--	--	--	--	--	--	---

Үндсэн чиг үүрэг 2: Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, судалгаа, мэдээллээр хэрэглэгчийг хангах.

93	Зорилт-3: Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх.	3.1.Хөрөнгө оруулалтын томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа боловсруулах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.	Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо	9	13	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	–“Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам”-ын шинэчилсэн төсөлд санал өгч, 2022.03.04-нд холбогдох газарт хүргүүлсэн. - Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг УИХ-ын ЭЗБХ-ны 2022.04.06-ны хуралдаанд танилцуулсан. –“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал өгч, холбогдох газарт хүргүүлсэн. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах сангийн яамны odamis.mof.gov.mn цахим системд бүртгэлтэй Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй зээлийн “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл”, буцалтгүй тусламжийн “Солонгос Монголын хамтарсан ховор металлын судалгааны төв байгуулах төсөл”, “Агаарын чанарыг сайжруулах эрчим хүчний нөөцийн чанарын удирдлагын чадавхыг бий болгох төсөл”, “Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээ”, “Цацраг идэвхт хаягдлын менежментийн нөөц бололцоог нэмэгдүүлэх” болон “Уур амьсгалын өөрчлөлт ба ухаалаг уул уурхай төсөл” Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Цөмийн энергийн комиссын Ажлын алба болон Геологийн судалгаа-шинжилгээний төв ТӨҮГ-т хэрэгжиж байгаа бөгөөд 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан.	100
94	Зорилт-4: Салбарын хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын талаар судалгаа хийх, статистик мэдээллээр хэрэглэгчийг хангах.	4.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын статистик мэдээллийг долоо хоног, сар, улирал, жилээр нэгтгэн боловсруулах, тайлагнах, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах.	Боловсруулсан статистик, мэдээллийн тоо	12	64	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Эрдэс баялгийн салбарын статистик мэдээллийг сар бүр боловсруулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. Үүнд: - Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар Монгол Улсын эдийн засагт (Эрдэс бүтээгдэхүүний экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл), Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, Эрдэс баялгийн салбарын төсөвт төвлөрүүлсэн орлого); - Аж үйлдвэрийн салбар (Уул уурхай, олборлох салбар, Хүнд үйлдвэрийн салбар, газрын тосны салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулсан бүтээгдэхүүн); - Гадаад худалдаа (Уул уурхай, олборлох салбарын экспорт, Газрын тосны экспорт, Хүнд үйлдвэрийн салбарын экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт).	100

							Мөн Монголбанк, Ашигт малтмал, газрын тосны газар, Гаалийн ерөнхий газар, Монголын Хөрөнгийн бирж ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК зэрэг байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл үндэслэн “Уул уурхай, газрын тосны салбарын 7 хоног”-ийн мэдээллийг боловсруулж удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. - Голлох ашигт малтмал болох алт, зэс, нүүрс, төмөр, жонш, уран, газрын ховор элемент, полиметалл, газрын тосны зах зээлийн судалгаа хийсэн. Мөн энэ судалгаандаа үндэслэн “Эрдэс баялгийн салбарын товч мэдээлэл 2023-2024” товхимолыг боловсруулж, хэвлүүлсэн. АНУ-ын Геологийн албанаас боловсруулсан “Mineral Commodity Summaries 2022, 2023, 2024” товхимолоос улс орнуудын ашигт малтмалуудын нөөц, үйлдвэрлэл зэрэг боловсруулж, судалгаандаа ашигласан. - Эдийн засгийн форумын хүрээнд тэргүүлэгч орнуудын эрдэс баялгийн салбар дахь бодлого, стратегийн эрдсийн ирээдүйн чиг хандлагын талаар судалгаа, мэдээлэл боловсруулсан. - Австрали Улсын ашигт малтмалын нөөц, уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын талаарх мэдээллийг боловсруулж удирдлагад танилцуулсан. - БНХАУ-ын нүүрсний зах зээлийн үнийн индексийн өөрчлөлт ба эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг www.sxcoal.com сайттай уялдуулан боловсруулж удирдлагыг мэдээллээр ханган ажилласан.	
95		4.2. Экспортод гаргаж буй ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох жишиг үнийг батлах, нийтэд мэдээлэх.	Зарласан жишиг үнийн тоо	12	48	Улсын төсөв	Монгол Улсын Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны 104/А131 тоот хамтарсан тушаалаар “Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлэх” үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 131 дүгээр тогтоол, 2016 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 465 дугаар тогтоолын дагуу Ажлын хэсгийн бүрэлдэхүүн сар бүрийн 10-ны дотор хуралдаж “Экспортод гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлж ажилласан.	100
7. Ерөнхий чиг үүргийн нэр: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах Үндсэн чиг үүрэг-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.								

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 2024 он

96	Зорилт-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	1.1. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгч, тайланг холбогдох газарт хүргүүлэх.	Зорилтот түвшин, хүрсэн түвшин хоорондын зөрүү	3.4	1.5	Улсын төсөв	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2023, 2024 оны хэрэгжилт, Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, УУХҮЯ-ны 2023, 2024 оны үйл ажиллагааны нэгдсэн тайланд зохих хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Эдийн засгийн яаманд хуулийн хугацаанд албан бичгээр тус тус хүргүүлж, цахим санд байршуулсан.	100
97	Зорилт-2: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.	2.1. Яамны дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийх.	Хийгдсэн аудитын тоо	0	5	Улсын төсөв	УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн "Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай" А/31 дүгээр тушаал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай" А/61 дүгээр тушаалаар ХШҮДАГ-ын 2023, 2024 оны дотоод аудитын төлөвлөгөөний дагуу аудит хийж, дотоод аудитын тайланг удирдлагуудад танилцуулсан. -ҮАГ-аас Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн 2019-2020 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах аудитын шалгалтын дагуу өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 1/1895 албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн. -Үндэсний аудитын газраас "Дархан Сэлэнгийн бүсэд уул уурхай, медаллургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концесснийн гэрээний хэрэгжилт, "Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо чиг үүргийн хэрэгжилт"-ийн талаар гүйцэт-гэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 03/2291 албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн.	100

							-Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайланг удирдлагад танилцуулав. ҮГА-д “Зөвлөмжийн хэрэгжилт ирүүлэх тухай” 03/715 дугаар албан бичгийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүргүүлэв. - Уул уурхай, хүнд үйлдвэрийн /хуучин нэрээр/ яамны 2023 оны худалдан авах ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн. - УУХҮ-ийн /хуучин нэрээр/ сайдын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/123 тоот тушаалын дагуу Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох журмын хэрэгжилтэд дотоод аудит хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Дотоод аудитын удирдамжийн дагуу ШУТИС-ийн ХШУС-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, аудитын тайланг бичиж байна. - ТНБД-ын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг “Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын ажлын алба”-ны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, ажлын тайланг ТНБД-д 2024 оны 8 дугаар сарын 22-ны өдөр танилцуулсан. АҮЭБСайдын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/56 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг АМГТГ, ҮГА, Геологийн судалгаа шинжилгээний төв ААТҮГ-т удирдамжийн дагуу дотоод аудит хийж, дотоод аудитын тайланг удирдлагад танилцуулсан.	
Үндсэн чиг үүрэг-2: АҮЭБЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.								
98	Зорилт-3: “Эрдэс баялгийн цахим засаглал” хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах.	3.1. “Эрдэс баялгийн цахим засаглал” үндэсний арга хэмжээний төсөл боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.	Боловсруулсан төсөл, хөтөлбөрийн тоо	0	1	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	“Эрдэс баялаг – Цахим шилжилт” хэлэлцүүлгийг 100% цахимаар хийсэн. Хэлэлцүүлэг 500 орчим оролцогчдыг хамарсан ба УУХҮЯ-ны зүгээс Эрдэс баялгийн цахим засаглалыг бүрдүүлэх нөхцөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулсан. УУХҮЯамны ТНБД-ын 2021.01.18-ны өдрийн А/05 дугаар тушаалаар “Салбарын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, уялдаа холбоог сайжруулах, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг төлөвшүүлэх зорилгоор яам болон агентлагуудын ашиглаж буй мэдээллийн сангуудын хэрэглээнд дүн шинжилгээ хийх, уялдаа холбоог хангах, нэгдсэн нэг системд нэгтгэх чиглэлээр санал боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг яам, агентлагуудад ашиглагдаж буй мэдээллийн сан, техник хангамж, программ хангамжийн судалгаанууд хэрэглээнд дүн шинжилгээ хийн, уялдаа холбоог хангах, нэгдсэн нэг	100

							системд нэгтгэх чиглэлээр санал дүгнэлт боловсруулсан. АҮЭБЯ-наас аж ахуй нэгж, иргэнд олгодог 16 төрлийн тусгай зөвшөөрлийн систем хөгжүүлэлтийг "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" ТӨҮГ-тай хамтран хийж дуусгаж license.mn-д байршуулж аж ахуй нэгж, иргэдийн хэрэглээнд нэвтрүүлсэн. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны цахим системийн 2-р шатны хөгжүүлэлтийг "Санхүүгийн мэдээллийн технологийн төв" ТӨҮГ-тай хамтран хийж дуусгасан. "Майкрософт Оффис 365"-ын албан ёсны лицензийг нийлүүлэх аж ахуй нэгжийг тендер зарлан сонгон шалгаруулж, гэрээ байгуулж худалдан авч албан хэрэгцээнд нэвтрүүлсэн. УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны цахим системүүдийн дэд бүтцийн уялдаа холбоог сайжруулах системийн шинжилгээ хийх ажлыг Австрали Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны (АМЕП II) хөтөлбөртэй хамтран гүйцэтгэж тайланг УУХҮЯ 2023 онд хүлээн авсан. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын шийдвэр гаргах түвшний, баталгаажуулалт хийх удирдах түвшний албан хаагчдад тоон гарын үсгийг олгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.	
99	Зорилт-4:Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээг цахимжуулж, түргэн шуурхай хүргэх.	4.1. УУХҮЯ, АМГТГ, ҮГА-аас олгодог тусгай зөвшөөрлүүд болон ЭБМЗ-ийн үйл ажиллагааг цахимжуулах, "E-Mongolia" платформд нэгдэх, аппликейшн нэвтрүүлэх.	Шинээр нэвтрүүлсэн аппликейшн	0	1	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр /E-Mongolia/ үзүүлдэг болох ажлын хүрээнд 5 үйлчилгээг /ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буцаан өгөх, үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох, тусгай зөвшөөрөлд хамаарах нөөцийн тодорхойлолт гаргах, хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох, тусгай зөвшөөрлийн лавлагаа/ сонгож, мэдээлэл, асуулга, судалгааг гарган төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбуулахаар ажлыг эхлүүлсэн. 2021 оны 5 дугаар сард тусгай зөвшөөрлийн бүртгэлтэй танилцах, лавлагаа авах үйлчилгээг E-Mongolia цахим системийн Уул уурхай хэсэгт холбуулсан. АҮЭБЯ-аас ААН-д олгодог тусгай зөвшөөрлийн бүртгэлийн систем хөгжүүлэлтийг хийж дууссан.Үүнд: Сайдын эрхлэх асуудлын хүрээнд олгодон тусгай зөвшөөрлийг https://license.mn/ платформоор дамжуулан 100 хувь цахимаар хүлээн авч тухай бүр шуурхай шийдвэрлэж байна. Мөн хайгуулын тусгай зөвшөөрлийн цахим системийн хөгжүүлэлтийг бүрэн хийж, төрийн худалдан авах ажиллагааны	100

							www.tender.gov.mn цахим хуудсанд байршуулан цахимаар шийдвэрлэж байна. ЭБМЗ-ийн хуралдааныг mpc.gov.mn Цахим хуудсаар дамжуулан цахимаар зохион байгуулж байна.	
НИЙТ ДҮН								76.8

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР